Бэлбэсэн	3.0	265	285	
Цуцалсан	4.3	376	327	
Тусгаарласан	2.8	247	208	
Огт гэрлэж эсвэл хамтран амьдарч байгаагүй	25.9	2,270	2,070	
<b>Хүүхэд төрүүлж байсан эсэх</b>				
Хүүхэд төрүүлж байсан	74.3	6,510	6,742	
Огт хүүхэд төрүүлж байгаагүй	25.7	2,252	2,020	
<b>Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эсэх</b>				
Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн	18.9	1,654	1,690	
Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлээгүй	81.1	7,108	7,072	

## 1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛАГА

			Хүснэгт 4-ийн үргэлжлэл
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	3.3	293	392
Бага	5.0	437	536
Суурь	18.9	1,655	1,958
Бүрэн дунд	28.7	2,514	2,426
Мэргэжлийн анхан шатны	10.0	878	891
Дээд	34.1	2,986	2,559
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>			
Доогуур	17.7	1,554	2,117
Дундажаас доогуур	19.2	1,681	1,906
Дундаж	20.4	1,790	1,771
Дундажаас дээгүүр	20.9	1,831	1,519
Дээгүүр	21.8	1,906	1,449
<b>Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс</b>			
Халх	81.2	7,118	6,600
Казак	3.3	288	481
Бусад	15.3	1,342	1,663
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.2	13	18
<b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг</b>			
Шүтлэггүй	41.7	3,656	3,945
Будда	51.0	4,470	4,122
Ислам	2.5	218	363
Бусад	4.4	387	299
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.4	31	33
<b>Бүгд</b>	100.0	8,762	8,762

**Хүснэгт 5:** Судалгаанд бүрэн хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн хувийн жин, зарим шинж байдлаар, Монгол Улс, 2010 он

	Жигнэсэн хувь	5 хүртэлх насны хүүхдийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	50.1	1,981	1,990
Эмэгтэй	49.9	1,975	1,966
<b>Бүс</b>			
Баруун	15.5	613	956
Хангай	22.2	877	787
Төв	18.7	739	810
Зүүн	7.4	292	709
Улаанбаатар	36.3	1,435	694
<b>Байршил</b>			
Хот	58.1	2,298	1,747
Хөдөө	41.9	1,658	2,209
<b>Суурьшил</b>			
Нийслэл	36.3	1,435	694
Аймгийн төв	21.8	863	1,053
Сумын төв	17.6	698	961
Хөдөө	24.3	960	1,248
<b>Нас</b>			
0-5 сар	11.4	452	455
6-11 сар	10.7	425	413
12-23 сар	23.9	944	897
24-35 сар	21.1	835	869
36-47 сар	17.7	701	703
48-59 сар	15.1	599	619
<b>Эх, асрамжлагчийн боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	4.6	181	235
Бага	7.9	312	366
Сүүрь	18.5	730	823
Бүрэн дунд	27.0	1,069	1,034
Мэргэжлийн анхан шатны	6.6	261	258
Дээд	35.5	1,403	1,240

## 1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛАГА

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Өрхийн аж байлын түвшин		Хүснэгт 5-ын үргэлжлэл	
Доогуур	23.5	930	1,213
Дунджаас доогуур	20.2	797	874
Дундаж	19.3	764	706
Дунджаас дээгүүр	18.7	738	608
Дээгүүр	18.4	727	555
Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс			
Халх	80.0	3,166	2,908
Казак	3.7	148	249
Бусад	16.0	635	787
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.2	8	12
Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг			
Шүтлэггүй	46.3	1,831	1,905
Будда	46.6	1,843	1,712
Ислам	2.9	117	196
Бусад	3.9	154	129
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.3	12	14
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>3,956</b>	<b>3,956</b>

**Хүснэгт 6:** Судалгаанд бүрэн хамрагдсан 15-54 насны эрэгтэйчүүдийн хувийн жин, зарим шинж байдлаар, Монгол Улс, 2010 он

	Жигнэсэн хувь	Жигнэсэн	Эрэгтэйчүүдийн тоо	Жигнээгүй
<b>Бүс</b>				
Баруун	13.5	542	863	
Хангай	20.8	839	777	
Төв	17.6	710	760	
Зүүн	7.6	307	758	
Улаанбаатар	40.5	1,628	867	
<b>Байршил</b>				
Хот	60.7	2,443	1,879	
Хөдөө	39.3	1,582	2,146	
<b>Суурьшил</b>				
Нийслэл	40.5	1,628	867	
Аймгийн төв	20.2	815	1,012	
Сумын төв	16.4	660	919	
Хөдөө	22.9	922	1,227	
<b>Нас</b>				
15-19	15.4	620	586	
20-24	14.5	585	524	
25-29	12.6	507	531	
30-34	14.5	585	591	
35-39	12.5	502	531	
40-44	11.4	460	479	
45-49	11.2	451	461	
50-54	7.8	314	322	
<b>Гэрлэлийн байдал</b>				
Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай	65.0	2,616	2,718	
Бэлбэсэн	0.7	29	30	
Цуцалсан	1.9	76	73	
Тусгаарласан	2.0	81	69	
Огт гэрлэж эсвэл хамтран амьдарч байгаагүй	30.4	1,223	1,135	
<b>Төрсөн хүүхэдтэй эсэх</b>				
Төрсөн хүүхэдтэй	65.1	2,622	2,723	
Төрсөн хүүхэдгүй	34.9	1,403	1,301	
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.0	1	1	

# 1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

			Хүснэгт 6-ийн үргэлжлэл
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	5.8	234	296
Бага	9.4	380	475
Суурь	26.2	1,055	1,162
Бүрэн дунд	25.7	1,034	932
Мэргэжлийн анхан шатны	10.4	417	417
Дээд	22.5	906	743
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>			
Доогуур	20.5	827	1,112
Дунджаас доогуур	18.4	742	820
Дундаж	19.5	785	764
Дунджаас дээгүүр	21.0	846	703
Дээгүүр	20.5	825	626
<b>Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс</b>			
Халх	80.4	3,238	2,984
Казак	3.8	154	255
Бусад	15.6	626	778
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.2	7	8
<b>Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг</b>			
Шүтлэггүй	44.0	1,773	1,884
Будда	48.7	1,961	1,810
Ислам	3.0	119	190
Бусад	3.8	154	121
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.5	19	20
<b>Буга</b>	100.0	4,025	4,025

**Хүснэгт 7:** Судалгаанд бүрэн хамрагдсан 2-14 насны хүүхдийн хувийн жин, зарим шинж байдлаар, Монгол Улс, 2010 он

	Жигнэсэн хувь	2-14 насны хүүхдийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	51.2	4,678	4,682
Эмэгтэй	48.8	4,453	4,449
<b>Бүс</b>			
Баруун	17.6	1,608	2,385
Хангай	22.3	2,034	1,773
Төв	19.2	1,749	1,826
Зүүн	8.3	758	1,772
Улаанбаатар	32.7	2,982	1,375
<b>Байршил</b>			
Хот	55.2	5,041	3,854
Хөдөө	44.8	4,090	5,277
<b>Суурьшил</b>			
Нийслэл	32.7	2,982	1,375
Аймгийн төв	22.6	2,059	2,479
Сумын төв	21.3	1,941	2,582
Хөдөө	23.5	2,149	2,695
<b>Нас</b>			
2-4	24.4	2,232	2,194
5-9	36.2	3,301	3,292
10-14	39.4	3,598	3,645
<b>Эх, асрамжлагчийн боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	4.3	395	483
Бага	8.0	731	846
Суурь	21.4	1,952	2,201
Бүрэн дунд	26.7	2,442	2,393
Мэргэжлийн анхан шатны	10.7	974	949
Дээд	28.9	2,636	2,258
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.0	1	1

## 1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛАГА

Хүснэгт 7-ийн үргэлжлэл


Өрхийн аж байдлын түвшин				
Доогуур	22.3	2,033	2,592	
Дунджаас доогуур	22.7	2,074	2,245	
Дундаж	19.3	1,764	1,700	
Дунджаас дээгүүр	19.2	1,755	1,452	
Дээгүүр	16.5	1,505	1,142	
Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс				
Халх	78.9	7,206	6,602	
Казак	4.4	403	628	
Бусад	16.5	1,510	1,885	
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.1	12	16	
Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг				
Шүтлэггүй	43.2	3,948	4,204	
Будда	49.4	4,515	4,141	
Ислам	3.4	310	484	
Бусад	3.6	326	273	
Хариулаагүй/ Мэдэхгүй	0.3	31	29	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>9,131</b>	<b>9,131</b>	

## **БҮЛЭГ 2**

**ЖИРЭМСЛЭЛТИЙН ӨМНӨХ ҮЕ**



## 2 ЖИРЭМСЛЭЛИЙН ӨМНӨХ ҮЕ



Гэр бүл төлөвлөлтийн зохиостой аргыг хэрэглэснээр хосууд төрүүлэх хүүхдийнхээ тоо, төрөлт хоорондын зайг зохицуулах боломжтой байдаг. Төрөлт хоорондын зайг зөв зохицуулах нь эх, хүүхдийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.

Хосуудын жирэмслэхээс сэргийлах арга, хэрэгсэл (ЖСАХ)-ийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, улмаар мэдлэгт суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх, түүнчлэн ЖСАХ-ийн хэрэгцээг хангах нь гэр бүл төлөвлөлтийн талаарх бодлогын гол зорилго юм. ЖСАХ нь орчин үеийн болон уламжлалт гэсэн хоёр төрөл байдаг.


Монгол улсын хэмжээнд 15-49 насны гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд бараг бүгд (97 хувь) ЖСАХ-ийн талаар мэддэг боловч ердөө талаас дөнгөж илүү хувь нь (55 хувь) одоогоор буюу судалгааны үед жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байжээ. ЖСАХ хэрэглэж байгаа нийт эмэгтэйчүүдийн 91 хувь нь орчин үеийн, 9 хувь нь уламжлалт арга хэрэглэж байна.

15-49 насны гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай нийт эмэгтэйчүүдийн 22 хувийнх нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдаагүй байна. Үүнийг бусад орнуудтай харьцуулбал (2007 оны байдлаар хөгжиж буй орнуудад дунджаар 11 хувь, Зүүн Азийн орнуудад дунджаар 2 хувь<sup>1)</sup>) харьцангуй өндөр байгаа тул хэрэгшээтэй байгаа боловч хэрэглэхгүй байгаа шалтгааныг гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй. ЖСАХ-ийн хэрэгцээтэй нийт эмэгтэйчүүдийн 71 хувийнх нь хэрэгцээ хангагдсан байна.

<sup>1</sup> <http://www.unfpa.org/public/home/publications/pid/6526>

# ЖИРЭМСЛЭЛТИЙН ӨМНӨХ ҮЕ


хот, хөдөөгөөр



Хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэг, хэрэглээ, хэрэгцээ харилцан адилгүй байна.

Тухайлбал, хотын эмэгтэйчүүд хөдөөгийн эмэгтэйчүүдээс ЖСАХ-ийн мэдлэгээрээ илүү (99 ба 95 хувь) боловч хэрэглээ нь бага (52 ба 59 хувь) байна. Мөн хотын эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээ нь хөдөөгийн эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад их (24 ба 20 хувь) байна.


## 2 ЖИРЭМСЛЭЛИЙН ӨМНӨХ ҮЕ БҮСЭЭР



Эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн дүр зургийг бүсээр авч үзэхэд Зүүн бүсийн хувьд бусад бүсээс ялгаатай байдал ажиглагдаж байна.

Тодруулбал, эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэг бүх бүсүүдэд жигд өндөр түвшинд (95-99 хувь) байгаа боловч Зүүн бүсийн эмэгтэйчүүд уг мэдлэгээ гэр бүл төлөвлөлтөндөө илүү зохистой хэрэглэж байна. Энэ нь тэдний ЖСАХ-ийн хэрэглээ нь хамгийн өндөр буюу 64 хувьтай, ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээ нь хамгийн бага буюу 16 хувьтай байгаагаас харагдаж болно.


## ЖИРЭМСЛЭЛИЙН ӨМНӨХ ҮЕ ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР




Эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн дүр зургийг тэдний амьдарч буй өрхийн аж байдааар авч үзэхэд ялгаатай байдал ажиглаглаа.

Дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэг хамгийн өндөр (99 хувь), хэрэглээ нь хамгийн бага (52 хувь) байхад энэ дүр зураг доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд эсрэг (мэдлэг нь 93 хувь, хэрэглээ нь 58 хувь) байна. Харин дунджаас дээгүүр болон дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн хэрэгцээ төдийлөн сайн хангагдаагүй (23 - 26 хувь), улмаар хангагдсан хэрэгцээ нь бага (67 - 69 хувь) байна.


## 2 ЖИРЭМСЛЭЛИЙН ӨМНӨХ ҮЕ ЗАРИМ ШИНЖ БАЙДЛААР



### ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээ, зорилгоор



### ЖСАХ-ийн талаар мэддэг эмэгтэйчүүдийн хувь, төрлөөр



### ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн хувь, төрлөөр



35-аас дээш насын эмэгтэйчүүдийн хувьд ЖСАХ-ийн хэрэглээ нь буурч түүнийгээ дагаад хангагдаагүй хэрэгцээ нь нэмэгдэж байна.

ЖСАХ-ийн талаар мэддэг эмэгтэйчүүдийн хувийг төрлөөр нь авч үзвэл 73 хувь нь ерөндөгийг мэддэг байхад 13 хувь нь тариаг мэддэг байна. Харин ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн 41 хувь нь ерөндөг хэрэглэж, 23 хувь нь эм ууж, 13 хувь нь хосын хамт эрэгтэй бэлгэвч хэрэглэж жирэмслэхээс сэргийлдэг байна.



Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насын нийт эмэгтэйчүүдийн 6 хувь нь төрөлт хоорондын зайгаа зохицуулахыг, 16 хувь нь төрүүлэх хүүхдийнхээ тоог хязгаарлахыг хүсч байгаа боловч ЖСАХ хэрэглэхгүй байна.

# **БҮЛЭГ 3**

## **ЖИРЭМСЭН ҮЕ**



### 3 ЖИРЭМСЭН ҮЕ



Төрөхийн өмнө жирэмсэн эхчүүлдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ нь тэдний эрүүл мэнд төдийгүй нялхсын эрүүл мэндэд маш чухал нөлөө үзүүлдэг. Мөн үр хөврөлийн өсөлт, хөгжил, эхийн эрүүл мэнд хоорондоо маш нарийн хамааралтай байдаг тул жирэмсэн үед мэргэжлийн эмчийн хяналтад хамрагдаж зохих заавар, зөвлөмж, үйлчилгээг авах нь маш чухал.



ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу жирэмсний хяналтад наад зах нь 4 удаа хамрагдсан байх хэрэгтэй. Мөн жирэмсний эхний 3 сарын хугацаанд жирэмсний хяналтад хамрагдах нь ургийн хөгжлийг хэвийн үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болдог. Жирэмсний хяналтын хүрээнд бүх эмэгтэйчүүд наад зах нь нэг удаа цусны даралтаа хэмжүүлэх, шээс, цус, бэлгийн замаар дамжих халдварт (БЗДХ)-ын шинжилгээ өгөх болон биеийн жингээ хэмжүүлэх хэрэгтэй байдаг бөгөөд эдгээр үйлчилгээнд бүгдэд нь бүрэн хамрагдах нь чухал.

Монгол улсын хэмжээнд судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүд бараг бүгд (99 хувь) наад зах нь 1 удаа мэргэжлийн эмчид үзүүлж жирэмсний хяналтад хамрагдсан бол 81 хувь нь 4 ба түүнээс олон удаа үзүүлсэн байна. Харин жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд жирэмсний эхний 3 сарын хугацаанд хяналтад хамрагдаж чадахгүй байх (23 хувь) явдал байсаар байна.

Жирэмсний хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд цусны даралтаа хэмжүүлэх, шээс болон цусны шинжилгээ өгөх, жингээ хэмжүүлэх нь нэлээд түгээмэл (бүгд 97 хувь) байхад БЗДХ-ын шинжилгээ өгөх нь арай бага (94 хувь) байна. Улмаар эдгээр үйлчилгээнд бүрэн хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь 91 байна.

# ЖИРЭМСЭН ҮЕ

## ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Жирэмсний хяналт болон түүний хүрээнд хамрагдвал зохих эрүүл мэндийн зарим үйлчилгээнд хот, хөдөөгийн эмэгтэйчүүд харилцан адилгүй хамрагдаж байна.

Хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд жирэмсний хяналтад хамрагдалт ижил түвшинд (наад зах нь 1 удаа - 99 хувь, наад зах нь 4 удаа - 82 ба 80 хувь) байна. Харин жирэмсний эхний 3 сарын хугацаанд хяналтад анх орсон хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувь хотын эмэгтэйчүүдийнхээс доогуур (73 ба 80 хувь) байна.

Мөн жирэмсний хяналтын хүрээнд цусны даралтаа хэмжүүлсэн эмэгтэйчүүдийн хувь хот, хөдөөд төдийлөн ялгаагүй боловч бусад шинжилгээнд хамрагдсан байдал нь ялгаатай байна. Тухайлбал, хөдөөгийн эмэгтэйчүүд цусны даралтаа хэмжүүлэхээс бусад үйлчилгээнд хотын эмэгтэйчүүдээс бага (шээсний шинжилгээ өгөх - 93 ба 99 хувь, цусны шинжилгээ өгөх - 94 ба 99 хувь, биеийн жин хэмжүүлэх - 95 ба 99 хувь), тэр дундаа БЗДХ-ын шинжилгээнд маш бага (87 ба 98 хувь) хамрагдаж байна. Үүнтэй уялдаад хамрагдвал зохих 5 үйлчилгээнд бүрэн хамрагдаж байгаа эмэгтэйчүүдийн хувь хот, хөдөөд нэлээд ялгаатай (84 ба 96 хувь) байгаа юм.


### 3 ЖИРЭМСЭН ҮЕ БҮСЭЭР



Жирэмсэн үеийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг бүсээр авч үзэхэд зарим үйлчилгээний хувьд харилсан адилгүй түвшинд байна.

Зүүн бусийн эмэгтэйчүүд жирэмсний хяналтын хугацаанд наад зах нь 4 удаа үзүүлэх нь улсын дунджаас 11 пунктээр өндөр байхад бусад бусийн хувьд улсын дундажтай ойролцоо (79-81 хувь) байна. Харин жирэмсний эхний 3 сарын хугацаанд хяналтад анх орох нь Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн хувьд Баруун болон Төвийн бусийн эмэгтэйчүүдийнхээс харьцангуй сайн (81 ба 72 хувь) байна.

Баруун бусийн эмэгтэйчүүдийн хувьд жирэмсний хяналтын хүрээнд хамрагдвал зохих (цусны даралт хэмжүүлэхээс бусад) үйлчилгээнүүдэд бусад бусийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй доогуур түвшинд хамрагдаж, тэр дундаа БЗДХ-ын шинжилгээнд хамрагдах нь бага (79 ба 93-99 хувь) байна. Харин бусад бусийн эмэгтэйчүүд бүх үйлчилгээнд ерөнхийдөө ижил түвшинд хамрагдаж байна.



# ЖИРЭМСЭН ҮЕ


## ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТУВШНЭЭР



Доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд жирэмсний хяналттай холбоотой эрүүл мэндийн үйлчилгээнд бусдаасаа бага хамрагддаг байна.


Тухайлбал, доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд жирэмсний хяналтын хугацаанд наад зах нь 4 удаа үзүүлэх нь хамгийн бага (78 ба 80-84 хувь) байна. Мөн өрхийн аж байдал доогуур байх тусам эмэгтэйчүүд жирэмсний эхний 3 сарын хугацаанд хяналтад анх орох нь багасч байна.

Түүнчлэн доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд жирэмсний хяналтын хүрээнд хамрагдвал зохих үйлчилгээнүүдэд бусдаасаа харьцангуй бага хамрагдаж байгаа ба мөн л БЗДХ-ын шинжилгээ өгөх явдлыг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.




### 3 ЖИРЭМСЭН ҮЕ ЗАРИМ ШИНЖ БАЙДЛААР

#### Жирэмсний хяналтад хамрагдлалт, хүүхэд төрүүлэх насаар



#### Жирэмсний хяналтад хамрагдлалт, үзүүлсэн хүнээр



20-иос дээш насандаа хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлсэн эмэгтэйчүүдийн 80 орчим хувь нь наад зах нь 4 удаа мэргэжлийн эмчид үзүүлж жирэмсний үеийн хяналтад хамрагдсан байхад энэ үзүүлэлт 20 хүртэлх насандаа хүүхдээ төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувьд 89 хувьтай байна. Харин 20 хүртэлх насандаа хүүхдээ төрүүлсэн эмэгтэйчүүдийнийн ердөө тал хувь нь жирэмсний эхний 3 сарын хугацаанд хяналтад анх орсон байна.


Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 100 эмэгтэй тутмын 61 нь өрхийн болон сумын эмчид, 32 нь эх барих эмэгтэйчүүдийн эмчид үзүүлжээ. Харин 100 эмэгтэй тутмын 1 нь жирэмсний хяналтад огт хамрагдаагүй байна.

# **БҮЛЭГ 4**

## **ТӨРӨХ ҮЕ**




## 4 ТӨРӨХ ҮЕ



Төрөлтийг эх барих чадвартай эмнэлгийн ажилтан удирдах, түүнчлэн эмнэлэгт төрөх нь эх, нярайн эсэн мэнд амаржихуйн үндсэн хүчин зүйл болдог. Эрүүл мэндийн шалтгааны улмаас эх болон хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учирахаар байвал эх барих үйл явцыг мэс заслын аргаар явуулж болдог. Нөгөө талаас, жирэмсэн эмэгтэйчүүд хүүхдээ төрүүлэх газар (улсын эсвэл хувийн эмнэлэг, амаржих газар г.м) болон хэлбэрийг (байгалийн жамаар эсвэл мэс заслын аргаар) бие даан эсвэл ойр дотныхныхоо тусламжтайгаар чөлөөтэй сонгох эрхтэй.


Монгол улсын хэмжээнд судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүд бараг бүгд (99 хувь) эмнэлэгт хүүхдээ төрүүлсэн ба энэ хугацаанд бараг бүх төрөлт (99 хувь) мэргэжлийн эмчийн хяналтан дор явагдсан байна.

ДЭМБ-аас нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрсөн байж болно гэж зөвлөдөг боловч энэ үзүүлэлт манай орны хувьд харьцангуй өндөр буюу судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 21 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна.




Хүүхэд төрүүлэх үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд ялгаагүй өндөр байна. Харин мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх явдал хотын эмэгтэйчүүдийн дунд илүү түгээмэл (23 ба 17 хувь) байна.

Хэдийгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж хот, хөдөөд ялгаагүй өндөр байгаа боловч үйлчилгээний чанарын асуудлыг тусад нь авч үзэх шаардлагатай байдаг.



## 4 ТӨРӨХ ҮЕ БҮСЭЭР





Хүүхэд төрүүлэх үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж бүсийн хувьд ялгаагүй буюу нэгэн жигд байна. Өөрөөр хэлбэл, хүүхдээ эмнэлэгт төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувь, мөн хүүхдээ мэргэжлийн эмчийн хяналтан дор төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувь бүх бүсэд жигд 98-99 хувьтай байна.

Харин Улаанбаатар хотын эмэгтэйчүүд хүүхдээ мэс заслын аргаар төрүүлэх явдал бусад бүсийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр, тэр дундаа Баруун болон Хангайн бүсийн эмэгтэйчүүдийнхээс илт өндөр байна. Энэ нь эрүүл мэндийн шалтгаантай байна уу эсвэл эмэгтэйчүүдийн өөрсдийн сонголтоос шалтгаалж байна уу гэдгийг цаашид гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй байж болох юм.

# ТӨРӨХ ҮЕ

## ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР





Хүүхэд төрүүлэх үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд бусдаасаа харьцангуй бага хүртэж байна.

Доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн эмнэлэгт хүүхдээ төрүүлсэн хувь нь бусдынхаасаа 3 хүртэлх пунктээр, мэргэжлийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлсэн хувь нь 2 хүртэлх пунктээр тус тус бага байна. Энэ нь хэдийгээр анхаарал татахуйц ялгаа биш мэт боловч доогуур түвшний аж байдалтай өрхөд амьдарч байгаа гэдэг нь тухайн үйлчилгээний хүртээмжид тодорхой хэмжээний ялгаа үүсгэж байгаа тул анхаарахад илүүдэхгүй.

Нөгөөтэйгүүр, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд хүүхдээ мэс заслын аргаар төрүүлэх нь доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийнхээс даруй 2 дахин их (31 ба 16 хувь) байгаагаас үзэхэд энэ нь эрүүл мэндийн шалтгаан гэхээс илүүтэйгээр эмэгтэйчүүдийн өөрсдийн сонголтоос шалтгаалж байж болох юм.

## Төрөх үеийн тусlamж, үйлчилгээ, хүүхэд төрүүлсэн насаар



Эмэгтэйн хүүхдээ төрүүлэх үеийн наснаас үл хамааран эрүүл мэндийн газарт болон мэргэжлийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлэх нь адил түвшинд байна.


35-аас дээш насандаа хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувьд мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх явдал их (35 хувь) байгаа ба энэ нь эмэгтэйн нас ахих тусам төрөх үеийн хүндэрэл үүсэх магадлал өндөр байдагтай холбоотой байж болох юм. Тухайлбал, 20 хүртэлх насандаа хүүхдээ төрүүлсэн 10 эмэгтэй тутмын 1 нь, 20-34 насандаа хүүхдээ төрүүлсэн 5 эмэгтэй тутмын 1 нь, 35-49 насандаа хүүхдээ төрүүлсэн 3 эмэгтэй тутмын 1 нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлж байна.

# БҮЛЭГ 5

НЯРАЙ ҮЕ



## 5 НЯРАЙ ҮЕ





Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулах шаардлагатай. Энэ нь тухайн нярайн амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөн торнихийн үндэс суурь болж өгдөг.

Эхчүүд ангир уургаа хүүхэддээ төрсний дараах 1 цагийн дотор амлуулснаар эх, хүүхэд хоёрын хооронд бие махбодийн болон сэтгэл зүйн холбоо үүсэхээс гадна хүүхэддээ дархлаа тогтооход чухал ач холбогдолтой. Энэхүү судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 10 эмэгтэй тутмын 7 нь төрсний дараах 1 цагийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулжээ. Манай орны хувьд хүүхдийг төрсөн даруйд нь жинлэх явдал түгээмэл (98 хувь) байна. Бага буюу 2,500 грамм хүрэхгүй жинтэй төрсөн хүүхэд хоол тэжээлийн эмгэгтэй, дархлаа султай, өвчлөмтгий болох эрсдэлтэй байдаг бөгөөд судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн 20 хүүхэд тутмын 1 нь бага жинтэй төржээ.

Хүүхдийг төрөнгүүт дархлааг нь сайжруулахын тулд сүрьеэ, халдварт саа, Б гепатитын эсрэг вакциныг (төрсний дараах 24 цагийн дотор) хийх шаардлагатай байдаг. Судалгаанд хамрагдсан 12-23 сартай нийт хүүхдийн 97-98 хувь нь төрөх үеийн дархлаалуулалтад хамрагдсан байна. Төрөх үеийн дархлаажуулалт харьцангуй өндөр байгаа нь бараг бүх хүүхэд эмнэлэгт төрж байгаатай холбоотой юм. Судалгаанд хамрагдсан 12-23 сартай нийт хүүхдийн 85 хувь нь дархлаажуулалтын карттай байсан байна.

Шинээр төрсөн хүүхдийг харьяа засаг, захиргааны нэгжийн Иргэний бүртгэл мэдээллийн хэлтэст бүртгүүлж, төрсний гэрчилгээг нь авах үүргийг эцэг, эх, ойр дотны хүмүүс нь хүлээдэг. Манай орны хувьд хүүхдийн бүртгэл харьшангүй өндөр түвшинд явагддаг нь судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдүүд бараг бүгд (99 хувь) бүртгэлтэй буюу төрсний гэрчилгээтэй байгаагаас харагдаж байна.

## НЯРАЙ ҮЕ ХҮЙСЭЭР






**Хамгаалал**

Хүүхдийн төрөх үеийн дархлаажуулалтад хамрагдалт хүйсээр ялгаагүй бөгөөд өндөр түвшинд (96-98 хувь) байна. Харин судалгаанд хамрагдсан 12-23 сартай эрэгтэй хүүхдүүдийн 87 хувь нь дархлаажуулалтын карттай байхад энэ үзүүлэлт эмэгтэй хүүхдүүдийн хувьд 83 хувь байна.

Шинээр төрсөн охид, хөвгүүдийг төрсний бүртгэлд ижил түвшинд (99 хувь) хамруулж байна.

## 5 НЯРАЙ ҮЕ ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Хамгаалал

Ерөнхийдөө хот, хөдөөгийн хүүхдүүд төрсний дараах нэг сарын дотор хамрагдвал зохих эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээнд ижил түвшинд хамрагдаж байна.


Тодруулбал, эхийн ангир уургаа төрсний дараах 1 цагийн дотор амласан, төрөнгүүт биеийн жинг нь хэмжсэн, бага жинтэй төрсөн, дархлаажуулалтын карттай, халдварт саагийн эсрэг вакцины төрөх үеийн тунд хамрагдсан, төрсний бүртгэлтэй хөдөөгийн хүүхдүүдийн хувь хотын хүүхдүүдийнхтэй ижил түвшинд (71 ба 72 хувь, 97 ба 99 хувь, 6 ба 4 хувь, 87 ба 83 хувь, 97 ба 98 хувь, 99 ба 99 хувь) байна. Харин сүрьеэгийн болон Б гепатитын эсрэг вакцинд хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдтэй харьцуулахад 3-5 пунктээр бага (96 ба 99 хувь, 94 ба 99 хувь) хамрагдаж байна.

# НЯРАЙ ҮЕ БҮСЭЭР



## 5 НЯРАЙ ҮЕ

### ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР




# **БҮЛЭГ 6**

## **НЯЛХ ҮЕ**



## 6 НЯЛХ ҮЕ





Төрсний дараах нэг нас хүртэлх хугацаа нь шинээр төрсөн хүүхдийн хувьд хамгийн анхаарал, халамж шаардлагад хугацаа билээ. Тиймээс энэ хугацаанд хүүхдийг хамрагдвал зохих бүх вакцинд хамруулж, хоол тэжээлийн зөв зохистой дэглэмийн дагуу хооллосноор дархлаа сүл байх, хоол тэжээлийн эмгэгт өртөх, өвчлөмтгий болох зэрэг эрсдэлүүдээс урьдчилан сэргийлж чадах юм.

Хүүхдийг 2 нас хүрэхээс нь өмнө сүрьеэгийн эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг вакцины 4 тун (төрөх үеийн, 1, 2, 3-р), Б гепатитын эсрэг вакцин, гуравт эсвэл тавт вакцины 3 тун (1, 2, 3-р), улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 1-р тунд бүрэн хамруулсан байх ёстой. Гуравт вакцины найрлагад сахуу, хөхүүг ханиад, татрангийн эсрэг вакцинууд ордог бол тавт вакцины найрлагад гуравт вакцин дээр нэмээд Б гепатит болон хемофилиюс инфлюенза Б-гийн эсрэг вакцинууд ордог.

Монгол улсын хэмжээнд 12-23 сартай нийт хүүхдийн хувьд улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 1-р тунд хамрагдах нь төдийлөн хангалттай бус (88 хувь) байна. Харин бусад вакцины хувьд хамрагдалтын түвшин харьцангуй өндөр (92-98 хувь) байна. Халдварт саагийн эсрэг болон гуравт эсвэл тавт вакцины 1-р тунд хамрагдалт харьцангуй өндөр (98 хувь, 96 хувь) түвшинд байгаа боловч 2, 3-р тунд хамрагдалт буурсан байдалтай (94-97 хувь, 92-94 хувь) байна. Үүнтэй уялдаад, хамрагдвал зохих бүх вакцинд бүрэн хамрагдсан хүүхдүүд нийт хүүхдийн 77 хувийг эзэлж байна.

ДЭМБ-аас хүүхдийг 6 сар хүртэл нь дан эхийн сүүгээр хооллож, 6 сараас нь эхлэн аажмаар зохистой нэмэгдэл хоолонд оруулахыг зөвлөдөг.

Манай орны хувьд судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 97 хувь нь хүүхдээ эхийн сүүгээр хооллож байжээ. Харин судалгаанд хамрагдсан 6 хүртэлх сартай нийт хүүхдийн 59 хувь нь эхийн сүүгээр дагнан хооллож байсан бол 6-8 сартай нийт хүүхдийн 78 хувь нь нэмэгдэл хоолонд орсон байжээ.





Х о о л т э ж э э л

Халдварт саагийн эсрэг болон гуравт эсвэл тавт вакцины хамрагдалтын түвшин хүйсийн хувьд ялгаагүй байна. Харин улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 1-р тунд охид илүү хамрагдаж (89 ба 86 хувь) байна. Ерөнхийдөө охид, хөвгүүдийн хувьд хамрагдвал зохих бүх вакцинад бүрэн хамрагдалт ижил түвшинд байна.

Мөн хүүхдийн хооллолтын байдлыг хүйсээр авч үзэхэд ялгаа төдийлөн ажиглагдахгүй байна.



## 6 НЯЛХ ҮЕ ХОТ, ХӨДӨӨГӨӨР



Хот, хөдөөгийн хүүхдүүдийн дархлаажуулалтад хамрагдалт, хооллолтын байдалд ялгаа төдийлөн ажиглагдсангүй.

Тодруулбал, хөдөөгийн хүүхдүүдийн дархлаажуулалтад хамрагдалт (85-98 хувь) хотын хүүхдүүдийнхтэй (89-98 хувь) ижил түвшинд байна. Мөн түүврийн алдааг харгалзан үзвэл хамрагдвал зохих бүх вакцинд бүрэн хамрагдсан хөдөөгийн хүүхдүүдийн хувь хотын хүүхдүүдийнхээс төдийлөн ялгаагүй (73 ба 80 хувь) гэж хэлж болохоор байна.

Хооллолтын байдлын хувьд эхийн сүүгээр хооллолт хот, хөдөөд ялгаагүй (98 ба 97 хувь) байхад эхийн сүүгээр дагнан хооллолт арай өндөр түвшинд (65 ба 55 хувь) байна. Харин хүүхдийг зохих хугацаанд нь нэмэгдэл хоолонд оруулах явдал хөдөөд хотынхоос харьцангуй доогуур (68 ба 85 хувь) байна.



Хүүхдийн дархлаажуулалтад хамрагдалт, хооллолын байдлыг бүсээр авч үзэхэд зарим ялгаатай байдал ажиглагдлаа.



Баруун болон Төвийн бүсийн хүүхдүүдийн дархлаажуулалтад хамрагдалт бусад бүсийн хүүхдүүдийнхээс харьцангуй доогуур түвшинд байна. Цаашлаад хамрагдвал зохих бүх вакцинд бүрэн хамрагдсан хүүхдийн хувь эдгээр бүсүүдээд хамгийн бага (67-68 ба 80-84 хувь) байна.

Улаанбаатар хотын хүүхдүүдийн эхийн сүүгээр дагнан хооллолт Баруун бүсийн хүүхдүүдийнхээс ялгаатай байна. Тодруулбал, Баруун бүсийн 0-5 сартай хүүхдүүдийн 72 хувь нь эхийн сүүгээр дагнан хооллож байхад энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 53 хувьтай байна.

Нэмэгдэл хоолонд орсон 6-8 сартай хүүхдийн тоо маш цөөн байгаа тул бүсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

## 6 НЯЛХ ҮЕ


### ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР



# **БҮЛЭГ 7**

**БАЛЧИР ҮЕ**





Хүүхдийг 2 нас хүртэлх хугацаанд тэдний хооллох хэв маягт ихээхэн анхаарал хандуулж, насанд нь тохирсон аюулгүй, тэжээллэг, чанартай, амин дэмээр баялаг хоол, хүнс өгөхийн зэрэгцээ эхийн сүүгээр хооллосоор байх шаардлагатай. Хоол, хүнсээр шимт бодис, бичил тэжээлийг зохих хэмжээнд авснаар хүүхэд бие бялдар, өсөлт хөгжил, оюун санааны хувьд эрүүл өсөн торних эх суурь тавигддаг.


Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллоод, 6 сартайгаас нь тохиромжтой нэмэгдэл хоолонд оруулж, улмаар 2 нас хүртэл нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохыг зөвлөдөг. Нэмэгдэл хоол өгөх давтамжийг хүүхдийн нас болон эхийн сүүгээр хооллож байгаа эсэхтэй нь уялдуулан нэмэгдүүлдэг. Тодруулбал, эхийн сүүгээр хооллож байгаа 6-8 сартай хүүхдэд өдөрт хамгийн баgадаа 2 удаа, 9-23 сартай хүүхдэд өдөрт хамгийн баgадаа 3 удаа нэмэгдэл хоол өгөхийг зөвлөдөг бол эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдэд сүүн шингэн зүйл (эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, малын сүү, лаазалсан, савласан эсвэл хуурай сүү болон тараг) болон нэмэгдэл хоолыг өдөрт хамгийн баgадаа 4 удаа өгөхийг зөвлөдөг.

Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 12-15 сартай нийт хүүхдийн 82 хувь нь 1 нас хүртлээ эхийн сүүгээр хооллож байсан бол 20-23 сартай нийт хүүхдийн 66 хувь нь 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон байна. Мөн 0-23 сартай нийт хүүхдийн 69 хувийг насанд нь тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож (6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллож, 6 сартайгаас нь нэмэгдэл хоолонд оруулахын зэрэгцээгээр эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон) байна. Хүүхдэд өгч буй нэмэгдэл хоол нь зохих давтамжиндаа хүрэхгүй тохиолдол маш түгээмэл байгаа нь 0-23 сартай нийт хүүхдийн дөнгөж 31 хувь нь өдөрт идвэл зохих давтамжийн дагуу нэмэгдэл хоол идэж байгаагаас харагдлаа.

Хүн амын дунд тохиолдож болзошгүй иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор өрхүүдийг хоол, хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэхийг зөвлөдөг. Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан нийт өрхийн 70 хувь нь иоджуулсан давсиг хоол, хүнсэндээ хэрэглэж байна.


# БАЛЧИР ҮЕ

## ХҮЙСЭЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР



Охид, хөвгүүдийн хооллолтын байдал ерөнхийдөө ойролцоо түвшинд байна.


Тухайлбал, 1 болон 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа, насандaa тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа, нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа охидын хувь 85, 68, 72, 28 байхад эдгээр үзүүлэлтүүд хөвгүүдийн хувьд харгалзан 79, 64, 66, 35 хувь байна.



Хүүхдийн хооллолтын байдлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд ерөнхийдөө ижил дүр зурагтай байна.

Тодруулбал, 1 болон 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа хүүхдийн хувь хот, хөдөөд ойролцоо байна. Мөн хүүхдийг насанд нь тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллох явдал хот, хөдөөд төдийлөн ялгаагүй (70 ба 67 хувь) байна. Түүнчлэн нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа хотын хүүхдүүдийн хувь хөдөөгийнхтэй ижил түвшинд (33 ба 28 хувь) байна.

Харин хотын өрхүүдтэй харьцуулахад хөдөөгийн өрхүүд иоджуулсан давсиг тэр бүр хоол, хүнсэндээ хэрэглэхгүй (77 ба 59 хувь) байгаагаас үзэхэд хөдөөгийн хүүхдүүд иод дутлын эмгэгт илүү өртөж болзошгүй юм.




Хүүхдийг хооллох хэв маяг, давтамжийг бүсээр авч үзэхэд Баруун болон Зүүн бүсүүдийн хувьд өөр хоорондоо болон бусад бүсээс ялгаатай дүр зураг ажиглагдлаа.

Тодруулбал, Баруун бүсийн хүүхдүүд 1 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллоо нь илүү (90 ба 69-81 хувь) байгаа боловч нэмэгдэл хоолыг зохих давтамжийн дагуу идэх нь хамгийн бага (16 ба 29-37 хувь) байна. Харин Зүүн бүсийн хүүхдүүдийг эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллоходоо тааруу (1 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхдийн хувь хамгийн бага буюу 69) байна. Бусад бүсийн хувьд эдгээр үзүүлэлтүүд ерөнхийдөө үлсны дундажтай ойролцоо байв.

Өрхүүдийн иоджуулсан давсны хэрэглээ бүсийн хувьд харилцан адилгүй буюу Баруун бүсийн өрхүүдийн тал хүрэхгүй хувь (48 хувь) нь хоол, хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэж байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн өндөр (80 хувь) байгаа нь тэд иоджуулсан давсны зах зээлд илүү ойр байдагтай холбоотой юм.

2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон 12-15 сартай хүүхдийн тоо маш цөөн байгаа тул бүсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

## БАЛЧИР ҮЕ ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТУВШНЭЭР



Хүүхдийн хооллох хэв маяг, давтамжийг тэдний амьдарч буй өрхийн аж байдлаар авч үзэхэд тодорхой хэмжээний ялгаа ажиглагдаж байна.

Тухайлбал, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийг 1 нас хүртэл нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох, мөн насанд нь тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллох нь төдийлөн хангалтгүй (70 хувь, 63 хувь) байгаа боловч нэмэгдэл хоолыг зохих давтамжаар өгөх нь хамгийн их (38 ба 24-35 хувь) байна. Харин эсрэгээр, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүд ихэвчлэн эхийн сүүгээр хооллож (1 нас хүртэл нь үргэлжлүүлэн хооллоот - 89 хувь, насанд нь тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллоот - 68 хувь) байгаа ба өдөрт нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэх нь хамгийн бага (24 ба 29-38 хувь) байна. Ер нь дунджаас дээгүүр аж байдалтай өрхийн эх, асрамжлагчид хүүхдээ харьцангуй зөв хэв маяг, давтамжаар хооллодог болох нь харагдлаа.

Иоджуулсан давсны хэрэглээ нь өрхийн аж байдалтай ихээхэн хамааралтай байгаа бөгөөд өрхийн аж байдал дээгүүр байх тусам иоджуулсан давсны хэрэглээ нэмэгдэж байна.

2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон 12-15 сартай хүүхдийн тоо маш цөөн байгаа тул өрхийн аж байдлаар ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.




# БҮЛЭГ 8

## 5 ХУРТЭЛХ НАС



## 8 | 5 ХҮРТЭЛХ НАС




5 хүртэлх насандaa хүүхэд хоол тэжээлийн эмгэгийн нэг хэлбэр болох уураг илчлэгийн дуталд орох магадлал өндөр байдаг. Уураг илчлэгийн дутал нь 3 хэлбэрээр илэрдэг. Хүүхдийн хувьд насандaa тохирогчгүй бага жинтэй байх нь цочмог болон архаг хэлбэрийн уураг илчлэгийн дутлыг илэрхийлдэг ба тураалтай байна гэж үздэг. Хүүхэд тураалтай байна гэдэг нь урт хугацааны уураг илчлэгийн дутлыг харуулж байгаа бөгөөд энэ нь хүүхдийн амь насанд эрсдэлтэй байдаг. Харин насандaa тохирогчгүй намхан байвал архаг хэлбэрийн уураг илчлэгийн дуталд орсон буюу өсөлт хоцролтой байна гэсэн үг юм. Зарим хүүхэд өндөртөө тохирогчгүй бага жинтэй байж болох ба энэ нь уураг илчлэгийн дутлын цочмог хэлбэрт орсныг илэрхийлж, туранхай байгааг илтгэнэ. Уураг илчлэгийн дутлын эдгээр үзүүлэтийг ДЭМБ-ын боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандартын дагуу жин/нас, өндөр/нас, жин/өндрийн харьцааны голчоос хэлбэлзэж байгаа Z оноогоор тооцдог ба дунд зэргийн ( $-3CX \leq Z \leq -2CX$ ), хүнд зэргийн ( $Z < -3CX$ ), дунд болон хүнд зэргийн ( $Z < -2CX$ ) гэсэн ангилалууд байдаг. Энэ тайлангийн хүрээнд дунд болон хүнд зэргийн уураг илчлэгийн дутлын талаар ярих болно. Энд: CX - стандарт хазайлт

5 хүртэлх насны хүүхдүүд уураг илчлэгийн дуталд орох явдал манай оронд байсаар байгаа ба тэр дундаа өсөлт хоцролтой хүүхдийн хувь харьцангуй өндөр буюу 16 хувь байна. Түүнчлэн тураалтай болон туранхай хүүхэд харгалзан 5 болон 2 хувьтай байна.

Манай орны хувьд нялхсын эндэгдэл 1,000 амьд төрөлтөд 36, харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 амьд төрөлтөд 45 байна. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тооцоходоо Брассын шууд бус аргыг ашигласан. Брассын шууд бус арга нь судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн амьдралынхаа туршид төрүүлсэн хүүхдийн тоо, амьд төрөөд эндсэн хүүхдийн тоо зэрэг мэдээллийг ашиглан хүүхдийн эндэх магадлалыг тооцдог арга юм. Энэ удаагийн судалгаанд 25-29 болон 30-34 насны эмэгтэйчүүдийн мэдээлэлд үндэслэн нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг дундажлан тооцоолсон бөгөөд 2004 оны 9 сараас 2007 оны 1 сар хүртэлх хугацааг хамаарсан. Мөн Монгол улсын хүн амын нас баралтын өмнөх үеийн тоо мэдээлэлд үндэслэн Коле-Деменийн Баруун загварын наслилийн хүснэгтийг уг тооцоонд ашигласан.

## 5 ХҮРТЭЛХ НАС ХҮЙСЭЭР




Хүүхдийн хоол тэжээлийн байдал, эндэх магадлалыг хүйсээр авч үзэхэд тодорхой хэмжээний ялгаатай байдал ажиглагдаж байна.

Тодруулбал, тураалтай болон туранхай охид, хөвгүүдийн хувь ижил түвшинд байгаа боловч 5 хүртэлх насны эрэгтэй хүүхдүүдийн дунд өсөлт хоцролт охидтой харьцуулахад 4 пунктээр илүү байна.

Мөн нялхсын эндэгдлийн түвшин эрэгтэй хүүхдүүдийн хувьд 1,000 амьд төрөлтөд 41 промиль байхад эмэгтэй хүүхдүүдийн хувьд энэ нь 31 промиль байна. Түүнчлэн 5 хүртэлх насны хөвгүүдийн хувьд эндэгдэх магадлал нь 1,000 амьд төрөлтөд 51 байгааг охидын эндэх магадлалтай (39 промиль) харьцуулахад харьшангуй өндөр байна.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Хот, хөдөөгийн хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал, эндэх магадлал ялгаатай байна.

Хоол тэжээлийн байдлын хувьд хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдийнхээс илүү өсөлт хоцролтой (20 ба 12 хувь) байна. Харин тураалтай болон туранхай хүүхдийн хувь хот, хөдөөд ижил түвшинд (4 ба 5 хувь, 3 ба 2 хувь) байна.

Хөдөөгийн хүүхдүүдийн 1 болон 5 хүртэлх насандaa эндэх магадлал хотын хүүхдүүдийнхээс 2-2.2 дахин их (нэг хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 24 ба 48, тав хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 28 ба 62) байна.

## 5 ХҮРТЭЛХ НАС БҮСЭЭР




Хүүхдийн хоол тэжээлийн байдал, эндэх магадлал бүсийн хувьд ялгаатай байна.

Баруун болон Хангайн бүсийн хүүхдүүдийн дунд өсөлт хоцролт хамгийн их (18-25 хувь) байна. Ялангуяа, өсөлт хоцролтой хүүхдийн хувь Баруун бүсэд Улаанбаатар хотынхаос даруй 2 дахин их (25 ба 12 хувь) байна.

Хүүхдийн 1 болон 5 хүртэлх насандаа эндэх магадлалыг бүсээр авч үзвэл Улаанбаатар хотын хүүхдүүдийн хувьд эндэх магадлал нь хамгийн бага (нэг хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 18, тав хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 21) байхад Хангайн бүсийн хүүхдүүдийн хувьд хамгийн өндөр (нэг хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 55, тав хүртэлх насны 1,000 хүүхэд тутмын 72) байна.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР



Хүүхдийн амьдарч буй өрхийн аж байдлаар тэдний хоол тэжээлийн байдал, эндэх магадлалыг авч үзвэл доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүд илүү өсөлт хоцролтой, эндэх магадлалтай байна.

Тодруулбал, өрхийн аж байдал доогуур байх тусам тураалтай, өсөлт хоцролтой хүүхдийн хувь ихсэх хандлагатай байна. Ялангуяа, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийнхээс эрс мүү (тураалтай хүүхдийн хувь - 2 ба 6, өсөлт хоцролтой хүүхдийн хувь - 7 ба 29) байна.

Хүүхдийн эндэх магадлал өрхийн аж байдлаар их ялгаатай байгаа бөгөөд өрхийн аж байдал дээгүүр байх тусам хүүхдийн 1 болон 5 хүртэлх насандaa эндэх магадлал 2.4-2.7 дахин багасч байна.


## 5 ХҮРТЭЛХ НАС НАСНЫ БҮЛГЭЭР



Хүүхдийн хоол тэжээлийн байдлыг насаар авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдлаа.

0-5 сартай нийт хүүхдийн дунд тураалтай, туранхай хүүхдүүдийн эзлэх хувийн жин 5 хүртэлх насны бусад хүүхдүүдтэй харьцуулахад хамгийн өндөр (тураалтай хүүхэд - 10 ба 3-5 хувь, туранхай хүүхэд - 7 ба 1-2 хувь) байна. Мөн 12-35 сартай 10 хүүхэд тутмын 2 нь өсөөлт хоцролтой (21 ба 8-15 хувь) байгаа нь бусад насныхантай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-1)




5 хүртэлх насын хүүхдийн хувьд хамгийн их эрсдэл дагуулдаг аюултай өвчинүүдийн тоонд уушгиний хатгалгаа болон суулгарт өвчинүүд зүй ёсоор ордог. Хүүхдийг өвдөхөөс урьдчилан сэргийлэх, өвдсөн тохиолдолд зохих арга хэмжээг авч, зөв үр дүнтэй эмчилгээ хийх нь өвчинийг хүндрүүлэхгүй байх, улмаар эрүүл мэнд, өсөлт хөгжил, амь насанд нь учирч болох эрсдэлийг бууруулахад чухал хүчин зүйл болно.

Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насын нийт хүүхдийн 2 хувь нь судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд уушгиний хатгалгаа өвчинөөр өвдсөн байж болзошгүй буюу ханиад хүрэх үедээ цээж нь хонхолзсоны улмаас амьсгал нь олширч саадтай болж байсан байна. Харин уушгиний хатгалгаа өвчиний шинж тэмдэг илэрсэн хүүхдүүдийн 87 хувийнх нь эх, асрамжлагчид мэргэжлийн эмчид хандсан бол 72 хувьд нь антибиотик эмчилгээ хийсэн байна. Эхчүүд аливаа өвчиний шинж тэмдгийг мэддэг байх нь хүүхдийнхээ өвчинийг хүндрүүлэхгүй түргэн шуурхай эрүүл мэндийн байгууллага эсвэл эмчид хандах нөхцлийг бүрдүүлдэг. Гэтэл судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насын хүүхдэтэй 15-49 насын нийт эмэгтэйчүүдийн ердөө 1 хувь нь уушгиний хатгалгаа өвчиний үндсэн 2 шинж тэмдгийг (хүүхдийн амьсгал нь олшрох эсвэл саадтай болох) мэдэж байгаа нь түйлийн хангалтгүй үзүүлэлт юм.

Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насын нийт хүүхдийн 10 хувь нь суулгийн 14 хоногийн хугацаанд суулгарт өвчинөөр өвдсөн байна. Суулгарт өвчиний үед шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолыг үргэлжлүүлэн өгөхийг зөвлөдөг. Шингэн сэлбэх эмчилгээнд үйлдвэрийн аргаар бэлтгэж савласан эсвэл гэрийн нөхцөлд зөвлөмжийн дагуу бэлтгэсэн шингэн сэлбэх уусмал өгөх эсвэл шингэн зүйлийг ердийн хэмжээнээс илүү өгөхийг ойлгоно. Судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд суулгарт өвчинөөр өвдсөн 5 хүртэлх насын нийт хүүхдийн 56 хувийг зөвлөмжийн дагуу буюу шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолыг үргэлжлүүлэн өгч эмчилсэн байна.

А аминдэмийн хэрэглээ нь хүүхдийн өсөлт хөгжил, дархалын системийг хэвийн байлгахад чухал ач холбогдолтой тул манай улсад ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 6-59 сартай хүүхдэд жилд 2 удаа өндөр тунт А аминдэмийн тосон бэлдмэлийг өгдөг. Судалгаанд хамрагдсан 6-59 сартай нийт хүүхдийн 61 хувь нь судалгаанаас өмнөх 6 сарын хугацаанд А аминдэм уусан байна.


## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-1) ХҮЙСЭЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР



Хүүхдийн эмчилгээ, асаргааны байдлыг хүйсээр авч үзэхэд төдийлөн ялгаагүй байна.

Судалгаанаас өмнөх 14 хоногийн хугацаанд суулгалт өвчинөөр өвдсөн эрэгтэй хүүхдүүдийн 58 хувьд нь шингэн сэлбэх эмчилгээ хийхийн зэрэгцээ хоолыг үргэлжлүүлэн өгсөн бол энэ үзүүлэлт эмэгтэй хүүхдүүдийн хувьд 56 хувь байна. Мөн А аминдэмийн хангамж охид, хөвгүүдийн хувьд ойролцоо буюу 61-62 хувьтай байна.

Уушгиний хатгалгаа өвчинөөр өвдсөн байж болзошгүй хүүхдүүдийн тоо маш цөөн байгаа тул мэргэжлийн эмчид хандсан байдал болон антибиотик эмчилгээ хийсэн байдлыг хүйсээр авч үзэх нь статистикийн хувьд боломжгүй юм. Мөн уушгиний хатгалгаа өвчний үндсэн 2 шинж тэмдгийг мэддэг эх, асрамжлагчдийн хувь маш бага байгаа тул хүйсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.




Хот, хөдөөгийн хүүхдүүдийн хувьд эмчилгээ, асаргааны байдал нь ерөнхийдөө ижил түвшинд байна.

Өөрөөр хэлбэл, хүүхдийг суулгалт өвчинөөр өвдсөн үед нь шингэн сэлбэх эмчилгээний зэрэгцээ хоолыг үргэлжлүүлэн өгсөн хувь (56 хувь), А аминдэм уусан хүүхдийн хувь (62 ба 61 хувь) зэрэг үзүүлэлтүүд хот, хөдөөд ижил түвшинд байна.

Уушгиний хатгалгаа өвчинөөр өвдсөн байж болзошгүй хүүхдүүдийн тоо маш цөөн байгаа тул мэргэжлийн эмчид хандсан байдал болон антибиотик эмчилгээ хийсэн байдлыг хот, хөдөөгөөр авч үзэх нь статистикийн хувьд боломжгүй юм. Мөн уушгиний хатгалгаа өвчний үндсэн 2 шинж тэмдгийг мэддэг эх, асрамжлагчдийн хувь маш бага байгаа тул хот, хөдөөгөөр ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-1)

### БҮСЭЭР, ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТУВШНЭЭР




Э м ч и л г э э , а с а р г а а

Хүүхдэд үзүүлэх эмчилгээ, асаргааны байдал Хангайн болон Зүүн бүсийн эх, асрамжлагчдын хувьд бусад бүсийнхэнтэй харьцуулахад сайн байна.

Баруун бүсийн болон Улаанбаатар хотын эх, асрамжлагчдын тал хувь (48-50 хувь) нь л хүүхдээ суулгалт өвчинөөр өвдсөн үед зохих эмчилгээг хийж байна.

Мөн Баруун бүсийн хүүхдүүдийн тал хувь (49 хувь) нь А амидэм ууж байхад бусад бүсийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 59-75 хувь байна. А амидэмжүүлэлтийн хамралт Зүүн болон Хангайн бүсэд хамгийн өндөр байв.

Уушгиний хатгалгаа өвчинөөр өвдсөн байж болзошгүй хүүхдүүдийн тоо маш цөөн байгаа тул мэргэжлийн эмчид хандсан байдал болон антибиотик эмчилгээ хийсэн байдлыг бүсээр авч үзэх нь статистикийн хувьд боломжгүй юм. Мөн уушгиний хатгалгаа өвчиний үндсэн 2 шинж тэмдгийг мэддэг эх, асрамжлагчдийн хувь маш бага байгаа тул бүсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.





Э м ч и л г э э , а с а р г а а

Хүүхдэд үзүүлэх эмчилгээ, асаргааг өрхийн аж байдалаар авч үзэхэд төдийлөн ялгаагүй байна.

Гагшүү, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүд суулгалт өвчинөөр өвдсөн үед тэдний эх, асрамжлагчид зөв, зохистой арга хэмжээг илүү авч (66 хувь) байна.

Уушгиний хатгалгаа өвчинөөр өвдсөн байж болзошгүй хүүхдүүдийн тоо маш цөөн байгаа тул мэргэжлийн эмчид хандсан байдал болон антибиотик эмчилгээ хийсэн байдлыг өрхийн аж байдалаар авч үзэх нь статистикийн хувьд боломжгүй юм. Мөн уушгиний хатгалгаа өвчиний үндсэн 2 шинж тэмдгийг мэддэг эх, асрамжлагчдийн хувь маш бага байгаа тул өрхийн аж байдалаар ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.

## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-2)





Хүүхдийг өвдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдний амьдарч буй орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нь маш чухал. Наад зах нь, өрхийн гишүүд ундны усны сайжруулсан эх үүсвэрээс усаа ууж, сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэж, хүүхдийнхээ ялгадсыг аюулгүй газарт зайлцуулж, гараа савангаар зориулалтын газарт угааж, хатуу түлш буюу нүүрс (чулуун, хүрэн, модны), шахмал түлш, мод, заг, бургас, аргал, хөрзөн, үртэс, дүгүй, хаймар зэргийг хоол, хүнсээ болгоходоо хэрэглэхгүй байвал хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх гадны хүчин зүйлийн нөлөө эрс буурах юм.

НҮБХС болон ДЭМБ-ын тодорхойлолтоор ундны усны сайжруулсан эх үүсвэр гэдэгт төвлөрсөн, төвлөрсөн бус системд холбогдсон сууцны хоолой болон нийтийн ус түгээх байр, гүний худаг, хамгаалагдсан энгийн худаг, хамгаалагдсан булаг, шанд, бороо, цасны ус болон цэвэршүүлж савласан ус (зөвхөн цэвэршүүлж савласан усныг ундандаа хэрэглээд, ахуйн хэрэглээний усаа бусад сайжруулсан эх үүсвэрээс авдаг бол) зэргийг авч үзээг. Энэ тодорхойлолтын дагуу ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээг тооцоход 65 хувьтай байна. Харин манай орны хувьд дээрх эх үүсвэрүүдээс гадна ундны усныг зориулалтын машинаар тээвэрлэж нийтийн ус түгээх байруудад түгээдэг эх үүсвэрийг сайжруулсан гэж үзэх боломжтой тул өмнөх судалгаанд тус эх үүсвэрийг сайжруулсан эх үүсвэр гэж үзсэн. Тиймээс өмнөх судалгаатай харьцуулах үүднээс энэ онцлогийг харгалzan ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээг тооцоход 78 хувьтай байна.

НҮБХС болон ДЭМБ-ын шинэчилсэн тодорхойлолтоор сайжруулсан ариун цэврийн байгууламж гэдэгт ус ургаж цэвэрлэдэг жорлон (ус нь төвлөрсөн ариутгах систем рүү, бохирын цооног руу, нүхэн жорлон руу эсвэл тодорхойгүй газар руу урсдаг), сайжруулсан болон энгийн нүхэн жорлон зэргийг авч үздэг хэдий ч ийм төрлийн ариун цэврийн байгууламж хэрэглэдэг мөртлөө бусад өрхүүдтэй хамтарч хэрэглэдэг эсвэл энэ нь нийтийн зориулалттай бол тухайн өрхүүдийг сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг гэж үзэхгүй. Үүний дагуу сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээг тооцоход 54 хувьтай байна. Харин өөрийн орны онцлогийг харгалzan үзэхийн зэрэгцээ өмнөх судалгаатай харьцуулах үүднээс бусадтай хамтран хэрэглэдэг эсэхээс үл хамааран сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээг тооцоход 83 хувь байна.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 67 хувь нь гар угаах зориулалтын газартайгаас гадна судалгааны үед эдгээр өрхийн 92 хувийн нь гар угаах газарт ус болон саван байсан байна. Судалгаанд хамрагдсан 2 хүртэлх насны нийт хүүхдийн 60 хувийнх нь ялгадсыг аюулгүй газарт зайлцуулсан (хүүхэд өөрөө жорлонд бие зассан эсвэл ялгадсыг жорлонд хаясан) байна. Харин судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн 68 хувь нь хоол, хүнсээ болгоходоо хатуу түлш хэрэглэдэг өрхөд амьдарч байна.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-2) ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Хүүхдийн амьдарч буй орчны эрүүл ахуйн нөхцөл байдал хот, хөдөөд нэлээд ялгаатай байна.

Тодруулбал, хөдөөд үндны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ (XXC 2005-ын тодорхойлолтоор - 61 ба 89 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 59 ба 69 хувь), сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээ (XXC 2005-ын тодорхойлолтоор - 59 ба 99 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 36 ба 66 хувь) хотынхоос доогуур түвшинд байна.


Мөн гар угаах зориуулалтын газартай өрхийн хувь (43 ба 82 хувь), хүүхдийн ялгадсыг аюулгүй газарт зайлуулсан байдал (44 ба 71 хувь) зэрэг үзүүлэлтүүд хөдөөд хотынхоос маш доогуур түвшинд байхын зэрэгцээ хатуу түлшний хэрэглээ (90 ба 54 хувь) хөдөөд хотынхоос бараг 2 дахин өндөр байна.

## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-2) БҮСЭЭР



Үндны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ

Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээ





Ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ Баруун болон Хангайн бүсэд хамгийн доогуур түвшинд байгаа бол сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээний хувьд эдгээр бүсүүдээс гадна Зүүн бүсэд мөн хамгийн доогуур үзүүлэлттэй байна.



Төвийн бүсийг Улаанбаатар хотоос бусад бүстэй харьцуулахад гар угаах зориулалтын газартай өрхийн хувь нь харьцангуй өндөр (65 хувь) байна. Хүүхдийн ялгадсыг аюулгүй газарт зайлцуулах тал дээр Улаанбаатар хотынхон хамгийн өндөр (73 хувь) үзүүлэлттэй байгаа бол Баруун бүсийнхэн хамгийн доогуур үзүүлэлттэй (44 хувь) байна. Энэ нь өрхийн ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдалтай холбоотой юм.

Баруун, Хангай, Зүүн бүсийн өрхүүдийн хувьд хатуу түлшний хэрэглээ хамгийн өндөр (78-87 хувь) байна.

## 8 | 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-2) ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР



## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3)



Хүүхдийн амьдралын эхний 3-4 жил нь тэдний оюун ухааны хөгжлийн хамгийн оргил үе гэж үздэг. Тиймээс энэ үед аливаа зүйлийг танин мэдэхэд нь эцэг эх, гэр бүлийн гишүүд дэмжлэг үзүүлдэг байх нь хүүхдийн хөгжлийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.



Ялангуяа өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүд, тэр дундаа эцэг, эх нь хүүхэдтэйгээ ном үнших, зурагтай ном үзэх, үлгэр, түүх ярьж өгөх, дуу дуулах, зугаалах, тоглох, эд юмс нэрлэх, тоо тоолох, зураг зурах гэх мэтээр цагийг хамт өнгөрүүлж дэмжлэг үзүүлэх нь хүүхдийн хөгжилд маш чухал. Судалгаанд хамрагдсан 3-4 насны нийт хүүхдийн 59 хувьд нь өрхийн хэн нэг гишүүн, 41 хувьд нь эцэг нь ийм маягаар дэмжлэг үзүүлсэн байна. Улсын хэмжээнд 3-4 насны нийт хүүхдийн 60 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Манай орны хувьд сургуулийн өмнөх боловсролыг цэцэрлэг болон хувилбарт сургалтаар олгодог.

Хүүхдэд зориулсан ном, тоглоом нь тэдний оюун ухааны чадамжийг хөгжүүлэх гол хэрэгсэл болдог. Монгол улсын хэмжээнд 5 хүртэлх насны нийт хүүхдийн дөнгөж 23 хувь нь 3 ба түүнээс олон хүүхдийн номтой, 68 хувь нь 2 ба түүнээс олон төрлийн (гар аргаар болон үйлдвэрийн аргаар хийсэн тоглоом, аяга, таваг г.м гэр ахуйн эд зүйл эсвэл мод, чулуу г.м гадны эд зүйл) тоглоом эсвэл түүнийг орлуулах зүйлээр тоглодог байна.

Хүүхдийг ганцааранг нь эсвэл өөр хүүхдээр харуулж гэрт нь үлдээх нь тэдний ахуйн осолд өртөх, гэмтэх эрсдлийг нэмэгдүүлэг. Судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд 1 цагаас илүү хугацаагаар ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны өөр хүүхдээр харуулж гэрт нь үлдээсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь 8 байгаа нь тийм ч бага үзүүлэлт биш юм.

Монгол улсад 3-4 насны хүүхдийн хөгжлийн индексийг анх удаа Олон улсын арга зүйн дагуу тооцож үзэхэд 88 гарсан бөгөөд үүнийг нарийвчлан авч үзвэл бие бялдын хөгжил болон сурах чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь хамгийн их (100 ба 99 хувь), нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь 87, харин үнших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь 15 байна. Үнших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадварыг харуулсан үзүүлэлт бусдаасаа хамгийн бага байгаа нь манай орны сургуулийн өмнөх боловсролын агуулгатай холбоотой юм. Нөгөө талаас, сургуулийн өмнөх боловсролоор олгодоггүй ийм чадварыг эзэмшсэн хүүхдийн хувь 15 байгаа нь тийм ч бага үзүүлэлт биш байж болох юм.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3) ХҮЙСЭЭР



Хүүхдэд үзүүлж буй халамж, анхаарал болон хүүхдийн хөгжлийн зарим үзүүлэлт охид, хөвгүүдийн хувьд ялгаатай байна.



Тухайлбал, гэр бүлийн гишүүд 3-4 насны охидод аливааг танин мэдэхэд нь арай илүү (62 ба 56 хувь) дэмжлэг үзүүлэх хандлага ажиглагдлаа. Харин сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт охид, хөвгүүдийн хувьд ойролцоо түвшинд (61 ба 58 хувь) байгаа ба эсгийн зүгээс охин, хүү гэж ялгалгүйгээр аливааг танин мэдэхэд нь адил тэгш (41 ба 42 хувь) дэмжлэг үзүүлдэг байна.

Хүүхдэд зориулсан ном, тоглоомтой байх нь охид, хөвгүүдийн хувьд төдийлөн ялгаагүй (3 ба түүнээс олон хүүхдийн номтой - 25 ба 21 хувь, 2 ба түүнээс олон төрлийн тоглоом, түүнийг орлуулах зүйлээр тоглодог - 67 ба 70 хувь) байна. Мөн гэртээ насанд хүрэгсдийн хараа хяналтгүй үлдсэн охид, хөвгүүдийн хувь ижил түвшинд (8 ба 9 хувь) байна.

Судалгаанд хамрагдсан 3-4 насны охидын хөгжил зарим талаараа хөвгүүдийнхээс арай илүү байна. Тодруулбал, унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа охидын хувь хөвгүүдийнхээс 5-9 пунктээр өндөр байна.

## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3)

### ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Хүүхэд үзүүлж буй анхаарал, халамж, дэмжлэгийг хот, хөдөө гэсэн ангилалаар авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдаж байгаа боловч хөгжлийн индексийн үзүүлэлт нь төдийлөн ялгаагүй байна.

Хөдөөгийн хүүхдүүдэд аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүдийн зүгээс дэмжлэг үзүүлэх нь хотын хүүхдүүдийнхээс харьцангуй бага (50 ба 65 хувь), мөн хөдөөгийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь хотын хүүхдүүдийнхээс нэлээд доогуур (47 ба 69 хувь) байна.


Хүүхдийн номтой хөдөөгийн хүүхдийн хувь хотын хүүхдүүдийнхээс нэлээд бага (13 ба 30 хувь), харин тоглоомтой хүүхдийн хувь хөдөөд хотынхоос 6 пунктээр илүү (72 ба 66 хувь) байна. Үүнийг хөдөөгийн хүүхдүүдийн дуна тоглоомыг мод, чулуу г.м гадны эд зүйлсээр орлуулан тоглох нь элбэг байдагтай холbon тайлбарлаж болох юм. Амьдрах орчны онцлог, нөхцөл байдал, амьдралын хэв маягаас хамаараад хүүхдийг ганцааранг нь эсвэл өөр хүүхдээр харуулж гэрт нь үлдээх нь хөдөөд илүү (11 ба 6 хувь) байна.

Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, бие бялдарын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар, сурах чадвар зэрэг нь зохих хэмжээнд байгаа хот, хөдөөгийн хүүхдийн хувь ижил түвшинд байна.

## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3) БҮСЭЭР





Б а г а н а с н ы х ү ү х ә д и й н х ө г ж л и й н и н д е к с



Төвийн бүсийн болон Улаанбаатар хотын хүүхдүүдэд гэр бүлийн гишүүд нь илүү цаг гаргадаг (65 хувь) ба эдгээр бүсийн хүүхдүүд бусад бүстэй харьцуулахад 3 ба түүнээс олон хүүхдийн номтой байх нь их (24-33 хувь) байна. Улаанбаатар хотоос бусад бүсийн хувьд хүүхдийг ганцааранг нь эсвэл өөр хүүхдээр харуулж гэрт нь үлдээх нь их (10-11 ба 4 хувь) байна.

Баруун болон Хангайн бүсийн хүүхдүүдийн тал хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа нь бусад бүстэй харьцуулахад харьцангуй бага (52 ба 62-67 хувь) үзүүлэлт хэдий ч бага наслын хүүхдийн хөгжлийн индекс нь бүсээр ялгаагүй байна.

## 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3) ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТУВШНЭЭР




Хүүхдэд үзүүлж буй халамж, анхаарал, дэмжлэг болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтай холбоотой үзүүлэлтүүд тэдний амьдарч буй өрхийн аж байдаар нэлээд ялгаатай байна.


Тухайлбал, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийг дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүдийн болон эцгийн зүгээс дэмжлэг үзүүлэх нь ойролцоогоор 1.5 дахин, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь 3 дахин, хүүхдийн номтой байх нь 8 дахин бага байна.

Хүүхдийн хөгжлийн индексийн үзүүлэлтүүд ерөнхийдөө өрхийн аж байдаас үл хамааран ижил түвшинд байгаа боловч унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа дээгүүр түвшний болон дунджаас дээгүүр аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувь бусдаас илүү (18-19 ба 12-13 хувь) байна.


## 8 5 ХҮРТЭЛХ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ-3) НАСНЫ БҮЛГЭЭР



Бага насын хүүхдийн хөгжил



Бага насын хүүхдийн хөгжил



Бага насын хүүхдийн хөгжлийн индекс

Хүүхдэд аливааг танин мэдэхэд нь үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой үзүүлэлтүүд хүүхдийн насаас үл хамааран харьцангуй ижил түвшинд (гэр бүлийн гишүүдийн дэмжлэг - 60 ба 57 хувь, эзгийн дэмжлэг - 41 ба 42 хувь) байхад сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь 4 настангуудын хувьд 68 хувь, 3 настангуудын хувьд 53 хувьтай байна.

Хүүхдийг сурч, хөгжихэд дэмжлэг болдог хүүхдийн ном, тоглоомтой байх нь насын хувьд ялгаатай байна. Тухайлбал, 2-4 насын хүүхдүүдийг бусадтай нь харьцуулахад 3 ба түүнээс олон хүүхдийн номтой байх нь 4 дахин (35 ба 8 хувь), 2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой байх нь 1.5 дахин (82 ба 53 хувь) илүү байна. Харин хүүхдийн нас ахих тусам ганцааранг нь эсвэл өөр хүүхдээр харуулж гэрт нь үлдээх нь нэмэгдэх (10 ба 7 хувь) хандлагатай байна.


Бие бялдарын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар, сурах чадвар зэрэг нь зохих хэмжээнд байгаа 3-4 насын хүүхдүүдийн хувь насаар төдийлөн ялгаагүй боловч унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа 4 настангуудын хувь 3 настангуудынхаас харьцангуй өндөр (21 ба 9 хувь) байна.

# БҮЛЭГ 9

## БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС



## 9 БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС



Хүүхэд сурч боловсрох эрхээ эдлэхэд төрийн бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээнээс гадна эцэг эх, гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцоо чухал юм.




Хүүхдийн бага боловсролд хамрагдаалтыг сургуульд бэлтгэгдсэн байдал, 1-р ангид элсэлтийн түвшин, бага боловсролын хамран сургалтын хувь (цэвэр), бага боловсрол эзэмшилтийн бохир жин, 1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцах магадлал зэрэг үзүүлэлтээр хэмждэг. Мөн боловсролын үзүүлэлтүүдийг зөвхөн албан боловсролын хувьд авч үзсэн.

Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сургуульд орохынхоо өмнө цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдаж байсан эсэхээр хэмждэг. Судалгааны үед 1-р ангид суралцаж байсан хүүхдүүдийн 91 хувь нь сургуульд орохын өмнө цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдаж байсан байна. Сургуульд орох насны нийт хүүхдийн 81 хувь нь 1-р ангид элсэн орсон бол тэдний 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцах магадлал 99 хувь байна. Бага боловсрол эзэмшилтийн бохир жин буюу судалгааны үед 5-р ангид суралцаж байсан хүүхдийн тоог бага боловсрол эзэмших насны нийт хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа 112 байна. Харин бага боловсролын хамран сургалтын хувь (цэвэр) 96 байна.

Хүүхдийн боловсролд анхаарахын зэрэгцээ тэднийг эерэг зан төлөвт сургах, буруу зан үйлийг нь өөрчлөхэд эцэг эх, гэр бүлийн гишүүд нь анхаарал хандуулж хүмүүжлийн эерэг аргыг зохистой хэрэглэх нь зүйтэй. Гэтэл манай оронд хүүхдэд хүмүүжлийн эерэг бус арга болох сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл оногдуулж хүмүүжүүлэх хандлага түгээмэл байна. Үүнийг 2-14 насны нийт хүүхдийн бараг тал хувь (46 хувь) нь судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд гэр бүлийн гишүүдийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэлийг ямар нэг байдлаар хүлээсэн байгаагаас харж болно.

Энэ удаагийн судалгаанд 2-14 насны хүүхдийн асуулгаар тэдний хөгжлийн байдал болон осол, гэмтэлд өртсөн байдлыг судалсан. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултуудыг тэдний эх, асрамжлагчдаас нь асуухад судалгаанд хамрагдсан 2-14 насны нийт хүүхдийн 14 хувь нь ямар нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй гэсэн дүн гарч байна. Харин 2-14 насны хүүхдийн 4 хувь нь судалгаанаас өмнөх 1 жилд ямар нэг төрлийн осол, гэмтэлд өртсөн байна.

# БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС ХҮЙСЭЭР






Хүүхдийн бага боловсролд хамрагдалт, хүмүүжил, эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүдийг хүйсээр авч үзэхэд тодорхой хэмжээний ялгаа ажиглагдаж байна.

Ерөнхийдөө бага боловсролд хамрагдалтын үзүүлэлтүүд охид, хөвгүүдийн хувьд бараг ялгаагүй байгаа боловч бага боловсрол эзэмшилтийн бохир жин хөвгүүдийн хувьд охидоос 7 пункктээр илүү (115 ба 108 хувь) байна.

Мөн хөвгүүдийг хүмүүжүүлэхдээ илүү их сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл оногдуулдаг (48 ба 43 хувь) бөгөөд тэд осол, гэмтэлд өртөх нь охидоос бага зэрэг илүү байна.

## 9 БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС ХОТ, ХӨДӨӨГӨӨР




Хөдөөгийн хүүхдүүдийн хувьд бага боловсролд хамрагддат болон эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд нь хотын хүүхдүүдийнхээс доогуур түвшинд байна.

Тухайлбал, сургуульд орох насны хөдөөгийн хүүхдийн 75 хувь нь 1-р ангид элсэн орсон байхад энэ үзүүлэлт хотод 86 хувьтай, мөн 1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцах магадлал хөдөөгийн хүүхдүүдийн хувьд 97 байхад хотын хүүхдүүдийн хувьд 100 хувьтай байна. Түүнчлэн бага боловсролын хамран сургалтын хувь (шэвэр) хөдөөд хотынхос доогуур хувьтай (94 ба 97 хувь) байгаа юм.



Хот, хөдөөд хүүхэд хүмүүжүүлэх арга, барил өрөнхийдөө ижил байна. Өөрөөр хэлбэл, эцэг эх, гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдэд сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл оногдуулах нь хот, хөдөөд ялгаагүй түгээмэл (47 ба 44 хувь) байна.

Эрүүл мэндийн хувьд хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс илүү хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй (15 ба 12 хувь) байгаа боловч осол, гэмтэлд өртсөн байдал хот, хөдөөд төдийлөн ялгаагүй (5 ба 4 хувь) байна.

# БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС БҮСЭР



Б а Г а б о л о в с р о л э з э м ш и л т и й н т а с р а л т гүй а н г и д 1-р а н г и д 5-р а н г и х ё р т л э э




Бага боловсролд хамрагдалтын үзүүлэлтүүд Баруун бүсийн хүүхдүүдийн хувьд хамгийн доогуур хувьтай байна. Харин Төвийн бүсийн хүүхдүүд сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл илүү (54 хувь) хүлээхийн зэрэгцээ илүү их хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй (19 хувь) байгаа юм.

Тодруулбал, Баруун бүсийн хүүхдүүдийн 83 хувь нь сургуульд орохосоо өмнө цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдсан, сургуульд орох насны хүүхдийн 70 хувь нь 1-р ангид элсэн орсон, бага боловсролд хамрагдах насны нийт хүүхдийн 94 хувь нь бага боловсролд хамрагдаж байгаа зэрэг нь хамгийн доогуур үзүүлэлтүүд болж байна. Харин Зүүн бүс болон Улаанбаатар хотын хувьд эдгээр үзүүлэлтүүд өндөр түвшинд байна.

Харин осол, гэмтэлд өртсөн хүүхдийн хувь Хангай, Төв, Зүүн бүсүүдэд өндөр (5-6 хувь) байна.

## 9 БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР




# БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС

## ЗАРИМ ШИНЖ БАЙДЛААР


2-14 насны хүүхдийн хувь, хүмүүжлийн аргын төрлөөр



Осол гэмтэлд өртсөн хүүхдийн хувь, төрлөөр



Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийн хувь, төрлөөр






# БҮЛЭГ 10

## СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС



## 10 СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС



Бага боловсролыг бүрэн эзэмших нь суурь боловсрол эзэмших эхлэл суурь юм. Хүүхдийн суурь боловсрол эзэмших нас нь тэдний хувьд нийгэмаа ойрийн гэсэн байр сууриа эзлэн төлөвших, цаашдын амьдралын гараагаа эхлэхэд нь чухал үе юм.



Суурь боловсролд хамрагдаж буй байдлыг дунд ангид дэвшин суралцсан хүүхдийн хувь, дунд боловсролын хамран сургалтын хувь (шэвэр), суурь боловсролын хамран сургалтын хувь (шэвэр) зэрэг үзүүлэлтээр үнэлдэг. Дунд боловсрол гэдэгт 6-9-р анги, суурь боловсрол гэдэгт 1-9-р ангийг авч үзсэн. Судалгаанаас өмнөх жилд бага боловсролын төгсөх анги буюу 5-р ангид суралцаж байсан хүүхдүүдийн 99 хувь нь судалгааны үед дунд ангид дэвшин суралцсанаас гадна дунд боловсролын хамран сургалтын хувь (шэвэр) 93, суурь боловсролын хамран сургалтын хувь (шэвэр) 96 байна.

Суурь боловсрол эзэмших насандaa хүүхдүүд хөдөлмөр эрхлэлтэд татагдан оролцох нь бий. Энэ нь хүүхдийн эдийн засгийн аливаа мөлжлэг, тэр дундаа тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хамгаалагдах эрхтэй зөрчилдэг.

НҮБХС-гийн шинэчилсэн тодорхойлолтоор хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг тооцоходо долоо хоногт наад зах нь 1 цаг эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаанд оролцсон эсвэл наад зах нь 28 цаг гэрийн ажил хийсэн 5-11 наасны хүүхдийг хөдөлмөр эрхэлсэн гэж үздэг бол 12-14 наасны хүүхдийн хувьд эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаанд оролцсон цагийг долоо хоногт наад зах нь 14 цаг, гэрийн ажил хийсэн цагийг наад зах нь 28 цаг гэж үздэг. Эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаагаа гэдэгт өөрийн өрхөөс гадуур хөлстэй, хөлсгүй хийсэн ажил, мөн өөрийн өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж хийсэн ажлыг ойлгохоос гадна өрхийнхөө хөрөгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх зэргийг багтаадаг. Энэ тодорхойлолтоор хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг тооцоход 28 хувьтай байгаа ба хөдөлмөр эрхэлж байгаа эдгээр хүүхдүүдийн 92 хувь нь сургуульд суралцаж байна.

Өрхийнхөө хөрөгцээнд ус зөөх, түлээ түлш бэлтгэх нь хүнд хүчир ажлын нэг хэлбэр мөн боловч Монгол хүүхдүүдийн хувьд хамгийн түгээмэл хийдэг ажлынх нь нэг тул манай орны хувьд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг тооцоходо үүнийг эдийн засгийн үйл ажиллагаагаа гэж авч үзэхгүйгээр гэрийн ажилд хамруулсан. Мөн наасны хувьд 5-17 наасыг авч үзсэн. Ингэснээр өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой болох юм. Ийнхүү өөрийн орны онцлогийг тусгасан тодорхойлолтын дагуу 5-17 наасны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг тооцоход 13 хувьтай байгаа ба хөдөлмөр эрхэлж байгаа эдгээр хүүхдүүдийн 88 хувь нь сургуульд суралцаж байна.


# СҮҮРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС ХҮЙСЭЭР



Дунд ангид дэвшин суралсан хүүхдийн хувь хүйсээр ялгаагүй (99 ба 99 хувь) байгаа боловч охидын дунд боловсролын хамран сургалтын хувь (шэвэр), түүнчлэн суурь боловсролын хамран сургалтын хувь (шэвэр) хөвгүүдийнхээс илүү (дунд боловсрол - 95 ба 91 хувь, суурь боловсрол - 97 ба 95 хувь) байна. Энэ нь анги ахих тусам хөвгүүдийн хувьд ямар нэг шалтгаанаар сургууль завсардах нь ихэсдэг байж болзошгүйг харуулж байна.

Хүүхдийн хөдөлмөрт охид, хөвгүүд ерөнхийдөө ижил түвшинда (XXC 2005-ын тодорхойлолтоор - 13 ба 13 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 31 ба 25 хувь) оролцдог байна. Харин хөдөлмөр эрхэлж буй хөвгүүдийн сургуульд хамрагдалт охидынхоос доогуур түвшинда (XXC 2005-ын тодорхойлолтоор - 83 ба 93 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 89 ба 95 хувь) байна.


## 10 СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС хот, хөдөөгөөр



Хөдөөгийн хүүхдүүдийн хувьд суурь боловсролд хамрагдалт хотын хүүхдүүдийнхээс доогуур түвшинд байна. Магадгүй энэ нь хөдөөгийн хүүхдүүдийн дунд хөдөлмөр эрхлэлт их байгаатай холбоотой байж болох юм.

Тодруулбал, дунд болон суурь боловсролын хамран сургалтын хувиуд (цэвэр) хөдөөгийн хүүхдүүдийн дунд хотын хүүхдүүдийнхээс доогуур (дунд боловсрол - 89 ба 96 хувь, суурь боловсрол - 95 ба 98 хувь) байхын зэрэгцээ хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хувь хөдөөд харьшангуй өндөр (XXC 2005-ын тодорхойлолтоор - 19 ба 8 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 38 ба 21 хувь), түүнчлэн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн сургуульд хамрагдалт хөдөөд хотынхоос нэлээд бага (XXC 2005-ын тодорхойлолтоор - 84 ба 95 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 89 ба 96 хувь) байна

# СҮҮРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС БҮСЭЭР




Хүүхэдийн суурь боловсролд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлтийн байдал бүсийн хувьд харилцан адилгүй байна.

Баруун, Хангай, Төвийн бүсийн хүүхдүүдийн суурь боловсролын хамран сургалтын хувь (цэвэр) бусад бүсийн хүүхдүүдийнхээс доогуур (95-96 ба 98 хувь) байгаагаас гадна илүү их хөдөлмөр эрхэлж (XXC 2005-ын тодорхойлолтоор - 17-18 хувь ба 6-9 хувь, XXC 2010-ын тодорхойлолтоор - 34-39 хувь ба 16-26 хувь) байна. Дунд боловсролын хамран сургалтын хувьд мөн Баруун болон Хангайн бүсүүд хамгийн доогуур (90 ба 93-96 хувь) үзүүлэлттэй байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлт хүүхдийн сурч боловсрох цаг, боломжийг хязгаарладаг болохыг илтгэж байгаа юм.

Улаанбаатар хотын хүүхдүүдийн хувьд бараг бүгд (100 хувь) дунд ангид дэвшиж суралцаж байгаагаас гадна дунд боловсролын хамран сургалтын хувь (цэвэр) хамгийн өндөр (96 ба 90-94 хувь) байна. Мөн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хувь Улаанбаатар хотод хамгийн бага (6 хувь) байхын зэрэгцээ тэдний сургуульд хамрагдалт бусад бүсүүдээс хамгийн өндөр (94 хувь) байна.

## 10 СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НАС ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР



Хүүхдийн амьдарч буй өрхийн аж байдал нь тэдний суурь боловсролд хамрагдлалт, хөдөлмөр эрхэлэлтэд ялгаатай байдлыг бий болгож байна.


Үүнийг хүүхдийн амьдарч буй өрхийн аж байдал доогуур байх тусам дунд болон суурь боловсролын хамран сургалтын хувиуд (шэвэр) бага, мөн энэ хэрээр хөдөлмөр эрхэлэлтэд оролцох нь нэмэгдэж байгаагаас харж болно. Ялангуяа доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн 98 хувь нь дунд ангид дэвшин суралцаж байгаа боловч дунд боловсролын хамран сургалтын хувь нь дөнгөж 84, суурь боловсролын хамран сургалтын хувь нь 92 байгаа ба энэ нь хамгийн бага үзүүлэлтүүд болж байна. Түүнчлэн доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувьд хөдөлмөр эрхэлт хамгийн өндөр (19 ба 5-15 хувь), мөн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн сургуульд хамрагдлалт хамгийн бага буюу дөнгөж 72 хувьтай байна.

# **БҮЛЭГ 11**


# **ЗАЛУУ НАС**




## 11 ЗАЛУУ НАС ХҮЙСЭР




Боловсрол



Мэдээллийн технологи



Архи, тамхины хэрэглээ



Амьдралын сэтгэл ханамж

Хүн залуу насандaa ихийг сурч, зөв дадал зуршилтай амьдарч, аливааг бүтээх хүсэл эрмэлзэлтэй байж, өөдрөг сэтгэлтэй амьдрах нь улс орны сайн сайхан ирээдүйг тодорхойлох хүчин зүйлсийн нэг болдог.

Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 15-24 насын нийт эрэгтэйчүүдийн 96 хувь, энэ насын нийт эмэгтэйчүүдийн 98 хувь нь бичиг үсэг мэдэж байна.


Манай орны залуучуудын дунд орчин үеийн техник, технологийн хэрэглээ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа ба судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд компьютер хэрэглэсэн 15-24 насын залуучуудын хувь (72 ба 72 хувь), интернет хэрэглэсэн залуучуудын хувь (60 ба 59 хувь) зэрэг үзүүлэлтүүд хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй байна.

Залуучууд сурч, боловсрохын зэрэгцээ зөв дадал зуршилтай байх нь чухал юм. Судалгаанд хамрагдсан 15-54 насын нийт эрэгтэйчүүдийн 16 хувь, 15-49 насын нийт эмэгтэйчүүдийн 1 хувь нь 15 нас хүрэхэсээ өмнө тамхи татаж үзсэн байна. Харин архи, согтууруулах ундааны хувьд 15-54 насын нийт эрэгтэйчүүдийн 3 хувь, 15-49 насын нийт эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхэсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзжээ.


Залуучууд амьдралдаа хэр сэтгэл хангалийн байдаг талаар судлахад судалгаанд хамрагдсан 15-24 насын залуучуудын дөнгөж 54 хувь нь судалгаанаас өмнөх нэг жилийн хугацаанд амьдралаа сайжирсан гэж хариулсан боловч залуу эрэгтэйчүүдийн 89 хувь, залуу эмэгтэйчүүдийн 92 хувь нь ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэсэн итгэлтэй байгаа нь Монгол залуучуудын ирээдүйдээ итгэх итгэл дүүрэн байгааг харуулж байна.

## ЗАЛУУ НАС


ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)




**Боловсрол**



**Мэдээллийн технологи**



**Архи, тамхины хэрэглээ**



**Амьдралын сэтгэл ханамж**

Хот, хөдөөгийн залуучуудын бичиг үсгийн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ ялгаатай түвшинд байна.


Тодруулбал, 15-24 насны хөдөөгийн эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг хотынхноос 10 пунктээр (89 ба 99 хувь) доогуур байхын зэрэгцээ компьютер болон интернетийн хэрэглээ хөдөөгийн залуу эрэгтэйчүүдийн хувьд хотын залуучуудынхаас 2.3-4.2 дахин бага (38 ба 88 хувь, 19 ба 79 хувь) байгаа нь дэд бүтцийн хөгжилтэй холбоотой юм.

Харин 15 нас хүрэхэсээ өмнө амьдралын муу зүршил болох тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэж үзэх нь 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн хувьд хот, хөдөөгөөр төдийлөн ялгаагүй (тамхи - 16 ба 17 хувь, архи, согтууруулах ундаа - 3 ба 2 хувь) байна.

Хотод амьдрах нэхцэл байдал хөдөөтэй харьцуулахад сонголт өргөн, боломж ихтэй байдагтай холбоотойгоор хотын залуучууд хөдөөгийнхнөөс илүүтэйгээр сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан (59 ба 45 хувь) гэж үзэхийн зэрэгцээ ирэх нэг жилд амьдралаа сайжирна (88 ба 83 хувь) гэсэн илүү их итгэлтэй байна.

## 11 ЗАЛУУ НАС

ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Хот, хөдөөгийн залуу эмэгтэйчүүдийн сурч боловсрох, зөв дадал зуршилтай амьдрах, амьдралдаа итгэлтэй байх байдал нь залуу эрэгтэйчүүдийнхтэйгээ адил дүр зурагтай байна.





Тухайлбал, судалгаанд хамрагдсан хотын залуу эмэгтэйчүүд бүгд бичиг үсэг мэддэг (100 хувь) байхад хөдөөгийн залуу эмэгтэйчүүдийн 94 хувь нь бичиг үсэг мэддэг байна. Үүнээс гадна компьютер болон интернетийн хэрэглээ 15-24 насны хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд эрс ялаатай (компьютерийн хэрэглээ - 83 ба 46 хувь, интернетийн хэрэглээ - 74 ба 24 хувь) байна.

Хотын залуу эмэгтэйчүүдийн амьдралдаа итгэх итгэл хөдөөгийн залуу эмэгтэйчүүдийнхээс илүү (сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн - 57 ба 47 хувь, ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэж үзсэн - 95 ба 86 хувь) байна.

15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо маш цөөн байгаа тул хот, хөдөөгөөр ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

# ЗАЛҮҮ НАС

БҮСЭЭР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)




Баруун, Хангай, Зүүн бүсийн залүү эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг бусдаасаа харьцангуй доогуур (89-92 ба 98-99 хувь) байхын зэрэгцээ компютер болон интернетийн хэрэглээ хамгийн бага (43-52 хувь, 23-33 хувь) байна.

15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтуурзуулах ундаа хэрэглэж үзсэн эрэгтэйчүүд Төвийн бүсэд хамгийн их (19 хувь, 3 хувь) байхад Баруун бүсэд хамгийн бага (12 хувь, 1 хувь) байна.


Харин залуучуудын амьдралд гарсан өөрчлөлт, тэдний ирээдүйд итгэх итгэлийн хувьд бүсээр тодорхой хэмжээний ялгаатай дүр зураг ажиглагдлаа. Хангайн бүсийн 15-24 насны эрэгтэйчүүдийн ердөө 38 хувь нь судалгаанаас өмнөх нэг жилийн хугацаанд амьдралаа сайжирсан гэж үзсэн байхад Улаанбаатар хотын залуучуудын 60 хувь нь мөн ийм үзэл бодолтой байна. Үүнээс гадна ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэсэн итгэлтэй байгаа залуучуудын хувь Хангайн болон Баруун бүсэд хамгийн доогуур (81-82 хувь), харин Төвийн бүсэд хамгийн өндөр (93 хувь) байна

## 11 ЗАЛУУ НАС


БҮСЭЭР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Б о л о в с р о л



М э д э э л л и н т е х н о л о г и




А мь д р а л ы н с э т г э л х а н а м ж

15-24 насны эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ, амьдралдаа итгэх итгэлийг харуулсан үзүүлэлтүүдийг бүсээр авч үзэхэд энэ насны эрэгтэйчүүдийнхтэй ижил дүр зурагтай байна.


15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтуурнуулах үндаа хэрэглэж үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо маш цөөн байгаа тул бүсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

# ЗАЛУУ НАС


ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)



Б о л о в с р о л



М э д э э л л и й н т е х н о л о г и




А р х и , т а м х и н ы х э р е г л э э

Залуу эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ, архи, тамхи, согтууруулах ундааны хэрэглээ, амьдралд итгэх итгэл зэргийг өрхийн аж байдаар авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдлаа.

Тухайлбал, доогуур түвшний аж байдалтай өрхийн 15-24 насны эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг хамгийн доогуур (81 хувь) байхын зэрэгцээ өрхийн аж байдал доогуур байх тусам компьютер болон интернет хэрэглэх боломж нь хязгаарлагдаж байна. Мөн доогуур түвшний аж байдалтай өрхийн залуу эрэгтэйчүүдийн хувьд амьдралдаа итгэх итгэл нь бусдаасаа доогуур үзүүлэлттэй байна.


15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэж үзэх нь дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эрэгтэйчүүдийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй (18 хувь, 5 хувь) байна.



А мь д р а л ы н с э т г э л х а н а м ж

## 11 ЗАЛУУ НАС

ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)




15-24 насны эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ, амьдралдаа итгэх итгэлийг харуулсан үзүүлэлтүүдийг өрхийн аж байдлаар авч үзэхэд энэ насны эрэгтэйчүүдийнхтэй ижил дүр зурагтай байна.


15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо маш цөөн байгаа тул өрхийн аж байдлаар ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

# ЗАЛҮҮ НАС

НАСНЫ БҮЛГЭЭР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)



Б о л о в с р о л



Мэдээллийн технологи



Архи, тамхины хэргэлээ

15-19 насны эрэгтэйчүүдтэй харьцуулахад 20-24 насныхны бичиг үсгийн мэдлэг 2 пунктээр, компьュтерийн хэрэглээ 8 пунктээр бага байхад интернэтийн хэрэглээ нь ижил түвшинд байна.


Сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн залуучууд насны хувьд ялгаагүй, харин ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэж үзсэн 20-24 насны залуу эрэгтэйчүүдийн хувь 15-19 насныхтай харьцуулахад 5 пунктээр илүү байна.

25-аас дээш насны эрэгтэйчүүдийн хувьд тамхи эрт татаж үзэх нь 15-24 насны эрэгтэйчүүдтэй харьцуулахад нэлээд өндөр байгаагаас үзэхэд сүүлийн жилүүдэд залуу эрэгтэйчүүдийн дунд тамхи эрт татаж үзэх явдал тодорхой хэмжээгээр багасч байна. Харин 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа үүж үзсэн эрэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 15-29 насныхны дунд өндөр (3-5 хувь) байгаа нь архи, согтууруулах ундааны хэрэглээ сүүлийн жилүүдэд нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм.



## 11 ЗАЛУУ НАС




НАСНЫ БҮЛГЭЭР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



15-24 насны залуу эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээ болон амьдралдаа итгэх итгэлийг насны бүлгээр авч үзэхэд дүр зураг нь энэ насны залуу эрэгтэйчүүдийнхтэй ижил байв.

15 нас хүрэхээсээ өмнө тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо маш цөөн байгаа тул насны бүлгээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд боломжгүй юм.

# ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ) ХҮЙСЭЭР



## Нөхөн үржихүй

## Б Э Л Г И Й И Н З А Н Г И Л

## Х Д Х В , Д О Х


Залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн зан үйл, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлагатай холбоотой асуудал үндэсний хэмжээний чухал асуудал юм.

Насанд хүрээгүй байхдаа буюу 18 нас хүрэхэсээ өмнө гэр бүлтэй болох нь залуучуудад тэр дундаа охидал эрүүл мэнд, хөгжилд сөргөөр нөлөөлж, охид, эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөх нөхцөлийг үүсгэх боломжтой байдаг. Эрт гэр бүлтэй болох, эрт хүүхэд төрүүлэх нь эмэгтэйчүүдийн хувьд сурч, боловсрох боломж нь багасах, улмаар жендерт суурисан ядууралд өртөх, нийгмээс тусгаарлагдах эрсдлийг нэмэгдүүлдэг. Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 20-54 насны эрэгтэйчүүдийн 2 хувь, 20-49 насны эмэгтэйчүүдийн 7 хувь нь 18 нас хүрэхэсээ өмнө гэр бүлтэй буюу хамтран амьдрагчтай болсон байна. Түүнчлэн 20-24 насны залуу эмэгтэйчүүдийн 2 хувь нь 18 нас хүрэхэсээ өмнө хүүхэд төрүүлжээ.

Залуучууд бэлгийн зөв зан үйтэй байх нь бэлгийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлж, эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл бодлог. Судалгаанд хамрагдсан 15-24 насны нийт эрэгтэйчүүдийн 3 хувь, нийт эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхэсээ өмнө бэлгийн хавьталаад орсон бол энэ насны залуу эрэгтэйчүүдийн 57 хувь, залуу эмэгтэйчүүдийн 46 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон байна. Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон залуу эрэгтэйчүүдийн 13 хувь, залуу эмэгтэйчүүдийн 1 хувь нь нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталаад оржээ. Хамгийн сүүлийн бэлгийн хавьталаад орохдоо бэлгэвч хэрэглэх нь сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталаад орсон залуу эрэгтэйчүүдийн хувьд 69 хувь байна. Харин сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталаад орсон залуу эмэгтэйчүүдийн тоо маш цөөн байгаа тул бэлгэвчийн хэрэглээг уг эмэгтэйчүүдийн хувьд тооцох боломжгүй байсан гэдгийг анхаарах хэрэгтэй.

Залуучууд бэлгийн замаар дамжих халдварт (БЗДХ)-ын талаар болон халдвараас хэрхэн өөрийгөө хамгаалах талаар мэдлэгтэй, эрүүл зан үйлийг хэвшүүлсэн байх нь чухал юм. ХДХВ-ийн халдварт бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн залуучуудыг ХДХВ-ийн халдварт талаарх цогц мэдлэгтэй гэж үздэг. Энэ үзүүлэлт 15-24 насны эрэгтэйчүүдийн дунд 29, эмэгтэйчүүдийн дунд 32 хувьтай байна. Мөн сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон залуу эрэгтэйчүүдийн 21 хувь, залуу эмэгтэйчүүдийн 17 хувь нь ХДХВ-ийн халдварт ирүүлэх шинжилгээ өгч, хариугаа авчээ.

## 11 ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ) ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)




Хот, хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд эрт гэр бүлтэй болох нь ижил түвшинд байна. Харин бэлгийн зан үйл болон ХДХВ-ийн халдварт талаарх мэдлэгийн хувьд хот, хөдөөгийн залуу эрэгтэйчүүдийн дунд ялаатай дүр зураг ажиглагдаж байна.


Тухайлбал, хотын залуу эрэгтэйчүүдийг хөдөөгийнхэнтэй харьцуулахад бэлгийн хавьтад илүү их (61 ба 48 хувь) орохын зэрэгцээ бэлгийн эрсдэлтэй зан үйлтэй (14 ба 10 хувь) байх хандлагатай байгааг сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьтад орсон хотын залуу эрэгтэйчүүдийн хувь хөдөөгийнхнөөс 4 пунктээр илүү байгаагаас харж болно. Харин сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьтад орсон бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьтад орохдоо бэлгэвч хэрэглэсэн залуу эрэгтэйчүүд хот, хөдөөгийн хувьд ижил түвшинд байна.

ХДХВ-ийн халдварт талаарх цогц мэдлэг хөдөөгийн залуучуудын дунд хотын залуучуудынхаас даруй 2 дахин бага байгаа бөгөөд сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьтад орсон бөгөөд ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан хөдөөгийн залуучуудын хувь хотынхныоос ойролцоогоор 3 дахин бага байна.


## ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ) ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Н е х ё н    γ р ж и х γ ѹ Й



Б э л г и й н    з а н    γ ѹ й л



Х    Δ    Х    В    ,    Δ    О    Х



Залуу эмэгтэйчүүдийн хувьд эрт хүүхэд төрүүлэх, ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэгтэй байх нь хот, хөдөөд нэлээд ялгаатай байна. Мөн 20-49 насны хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд эрт гэр бүлтэй болох нь харилсан адилгүй байна.

Тодруулбал, хөдөөгийн эмэгтэйчүүдийг хотынхонтой харьцуулахад эрт гэр бүлтэй болох хандлагатай (9 ба 5 хувь) байгаагаас гадна хөдөөгийн залуу эмэгтэйчүүд 18 нас хүрэхэсээ өмнө хүүхэд төрүүлэх нь их (5 ба 1 хувь) байна.

Залуу эмэгтэйчүүдийн ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэг, дадлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд залуу эрэгтэйчүүдийнхтэй ижил дүр зурагтай байна.

15 нас хүрэхэсээ өмнө бэлгийн хавьтад орсон залуу эмэгтэйтэйчүүдийн хувь, сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьтад орсон залуу эмэгтэйчүүдийн хувь зэрэг үзүүлэлтүүд маш бага түвшинд байгаа тул хот, хөдөөгөөр ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.

## 11 ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ) БҮСЭЭР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)






Залуу эрэгтэйчүүдийн бэлгийн зан үйл, ХДХВ-ийн халдвартын талаарх мэдлэг, дадал зэрэг нь бүсээр тодорхой хэмжээний ялгаатай байна. Мөн 20-54 насны эрэгтэйчүүдийн хувьд эрт гэр бүлтэй болох нь бүсээр ялгаатай байна.

Тухайлбал, 18 наснаасаа өмнө гэр бүлтэй болох нь Баруун бүсийн 20-54 насны эрэгтэйчүүдийн хувьд хамгийн бага (1 хувь) байхад Төвийн бүсийнхний хувьд хамгийн их (3 хувь) байна. Мөн Төвийн бүсийн залуу эрэгтэйчүүдийн хувьд 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьтад орох нь Зүүн бүсийнхээс илүү (5 ба 1 хувь) байна. Улаанбаатар хотын залуу эрэгтэйчүүдийн хувьд сүүлийн 12 сард бэлгийн хавьтад орсон болон энэ хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьтад орсон зэрэг үзүүлэлтүүд (64 хувь, 16 хувь) Баруун бүсийнхэнтэй харьцуулахад их (36 хувь, 8 хувь) байна. Харин бэлгийн эрсдэлтэй зан үйтэй залуу эрэгтэйчүүдийн хувьд бэлгэвчийн хэрэглээг бүсээр тооцох боломжгүй байсныг дурдах хэрэгтэй.

Харин 15-24 насны эрэгтэйчүүдийн хувьд ХДХВ-ийн халдвартын талаарх цогц мэдлэг болон ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авах нь Улаанбаатар хотод хамгийн их (39 хувь, 26 хувь), Баруун бүсэд хамгийн бага (13 хувь, 12 хувь) байна.

## ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ) БҮСЭЭР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Залуу эмэгтэйчүүдийн хувьд эрт хүүхэд төрүүлэх байдал, бэлгийн зан үйл, ХДХВ-ийн халдварт талаарх мэдлэг зэрэг, дадал нь бүсээр ялгаатай байна. Мөн судалгаанд хамрагдсан 20-49 насны эмэгтэйчүүдийн хувьд эрт гэр бүлтэй болох нь бүсээр ялгаатай байна.



Тодруулбал, Улаанбаатар хот болон Баруун бүсийн 20-49 насны эмэгтэйчүүд эрт гэр бүлтэй болох нь бусад бүсийнхэнтэй харьцуулахад хамгийн бага (4-5 хувь) байна. Мөн сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон 15-24 насны эмэгтэйчүүдийн хувь Баруун бүсэд хамгийн бага (28 хувь) байна.

15-24 насны эмэгтэйчүүдийн ХДХВ-ийн халдварт талаарх цогц мэдлэг Баруун бүсэд хамгийн бага (16 ба 23-39 хувь), харин сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон бөгөөд ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан эмэгтэйчүүдийн хувь Хангайн бүсэд хамгийн бага (8 ба 13-21 хувь) байна.

15 нас хүрэхэсээ өмнө бэлгийн хавьталаад орсон залуу эмэгтэйтэйчүүдийн хувь, сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталаад орсон залуу эмэгтэйчүүдийн хувь зэрэг үзүүлэлтүүд маш бага түвшинд байгаа тул бүсээр ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.

## 11 ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ)

ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-24 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)





Бэлгийн зан үйл, ХΔХВ-ийн халдварт талаарх мэдлэг, дадлыг залуу эрэгтэйчүүдийн амьдарч буй өрхийн аж байдааар авч үзэхэд зарим үзүүлэтийн хувьд ялгаатай байна.

Бэлгийн зан үйлийн хувьд дээгүүр түвшний болон дунджаас дээгүүр аж байдалтай өрхийн залуу эрэгтэйчүүд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьтад илүү (15 ба 10-13 хувь) орох хандлагатай байна. Харин бэлгийн эрсдэлтэй зан үйтэй залуу эрэгтэйчүүдийн хувьд бэлгэвчийн хэрэглээг өрхийн аж байдааар тооцох боломжгүй байсныг дурдах хэрэгтэй.

Мөн өрхийн аж байдал дээгүүр байх тусам залуу эрэгтэйчүүдийн ХΔХВ-ийн халдварт талаарх цогц мэдлэг илүү (48 ба 12-33 хувь) байгаа бөгөөд үүнийгээ дагаад ХΔХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авах нь ч их (31 ба 6-22 хувь) байгаа юм.

## ЗАЛУУ НАС (ҮРГЭЛЖЛЭЛ)

ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-24 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Доогуур түвшний аж байдалтай өрхийн залуу эмэгтэйчүүдийн эрт хүүхэд төрүүлэх байдал, бэлгийн зан үйл, ХДХВ-ийн халдвартын талаарх мэдлэг, дадал нь бусад эмэгтэйчүүдийнхээс эрс ялгаатай байна. Мөн 20-49 насны нийт эмэгтэйчүүдийн хувьд 18 нас хүрэхээсээ өмнө гэр бүлтэй болох нь өрхийн аж байдлаар ялгаатай байна.

Өөрөөр хэлбэл, доогуур түвшний аж байдалтай өрхийн 20-49 насны эмэгтэйчүүдийн дунд эрт гэр бүлтэй болох явдал их (12 ба 4-8 хувь) байгаа төдийгүй 20-24 насны эмэгтэйчүүдийн дунд эрт хүүхэд төрүүлэх явдал хамгийн их (6 хувь) байна. Мөн сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталаад орсон доогуур түвшний аж байдалтай өрхийн залуу эмэгтэйчүүдийн хувь хамгийн их (54 ба 41-47 хувь) байгаа юм.

Түүнчлэн доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн халдвартын талаарх цогц мэдлэг болон ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авах нь хамгийн бага (17 хувь, 7 хувь) байна.

15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталаад орсон залуу эмэгтэйтэйчүүдийн хувь, сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталаад орсон залуу эмэгтэйчүүдийн хувь зэрэг үзүүлэлтүүд маш бага түвшинд байгаа тул өрхийн аж байдлаар ялгаа ажиглах нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.




# БҮЛЭГ 12

## НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС



## 12 НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС ХҮЙСЭР



Насанд хүрэгчдийн эрүүл мэнд, амьдралын дадал зуршил, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага нь тэдний гэр бүл болон үр хүүхдийн ирээдүйд маш чухал юм.

Аливаа улс орны хүн амын дунд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ өндөр байснаар улс орны хэмжээний мэдээ, мэдээллийг иргэдэл тухай бүр хүргэх боломжтой болох юм. Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан 15-54 насны эрэгтэйчүүдийн 24 хувь, 15-49 насны эмэгтэйчүүдийн 23 хувь нь судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд сонин уншиж, радио сонсож, телевизор үзсэн байна.


Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсийн хувьд маш их ялгаатай байна. Тухайлбал, 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн 81 хувь нь тамхи татаж үзсэн байхад энэ нь 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн дуна 26 хувьтай байна. Судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн ойролцоогоор тал хувь (54 ба 49 хувь) нь тамхи татаж, архи, согтууруулах ундаа уусан байна. Харин 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 6 хувь нь судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд тамхи татсан, 22 хувь нь судалгаанаас өмнөх 1 сард архи, согтууруулах ундаа уусан байна.

Хүүхэд хүчирхийлэлтэй гэр бүлд амьдрах нь түүний хөгжил, хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс насанд хүрэгчдийн гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага нэн чухал юм. Судалгаанд хамрагдсан 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн 9 хувь, 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 10 хувь нь нөхөр нь эхнэрээ тодорхой тохиолдуудад цохиж зодож болно гэдэгтэй санал нийлсэн байна.

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судлахад судалгаанд хамрагдсан нөхөн үржихүйн насны (15-54 нас) эрэгтэйчүүдийн 88 хувь, нөхөн үржихүйн насны (15-49 нас) эмэгтэйчүүдийн 93 хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар сонссон боловч мэдлэг, хандлага, дадлын хувьд маш хангальгүй байдал ажиглагдаж байна. Тухайлбал, ХДХВ-ийн халдвартай талаарх цогц мэдлэгтэй буюу ХДХВ-ийн халдвартай замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн эрэгтэйчүүдийн хувь 26, эмэгтэйчүүдийн хувь 29, мөн ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлагатай эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь харгалзан 4 ба 5 байна. Түүнчлэн ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлагатай эмэгтэйчүүдийн хувь 62, эмэгтэйчүүдийн хувь 70 байгаа боловч ердөө 12-13 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд уг шинжилгээг өгч, хариугаа авсан байна.

# НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС

## ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-54 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)




Хот, хөдөөгийн хүн амын дунд олон нийтийн мэдээлийн хэрэгслийн хүртээмж ялгаатай байна. Тухайлбал, сонин уншиж, радио сонсож, телевизор үзэж байгаа хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувь хотынхноос 2.6 дахин бага байгаа юм. Энэ нь дэд бүтцийн хөгжил хөдөөд муу байдагтай холбоотой юм.

Тамхины хэрэглээ хот, хөдөөгийн эрэгтэйчүүдийн дунд ялгаагүй байгаа боловч архи, согтууруулах ундааны хэрэглээ хотод илүү их (53 ба 43 хувь) байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагын хувьд хөдөөгийн эрэгтэйчүүд хотынхонтой харьцуулахад нөхөр нь эхнэрээ тодорхой тохиолдлуудад цохиж зодохтой илүү санал нийлж (13 ба 6 хувь) байна.

ХДХВ, DOX-ын талаар сонссон (93 ба 81 хувь), ХДХВ-ийн халдварын талаарх цогц мэдлэгтэй (34 ба 15 хувь), ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хаана өгөхийг мэддэг (72 ба 46 хувь), судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд уг шинжилгээг өгч, хариуугаа авсан (15 ба 7 хувь) нөхөн үржихүйн насын хотын эрэгтэйчүүдийн хувь хөдөөгийнхнөөс илүү байна. Харин ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлага хот, хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд ижил түвшинд (5 ба 6 хувь) байна.

## 12 НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС ХОТ, ХӨДӨӨГӨӨР (15-49 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)




Хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ харилцан адилгүй (хотод 30 хувь, хөдөөд 11 хувь) байна. Энэ нь өмнө дурдсанчлан дэд бүтцийн хөгжил хөдөөд муу байдагтай холбоотой юм.

Харин хорт зуршлын хувьд хотын эмэгтэйчүүд архи, тамхийг илүү хэрэглэх хандлагатай байгаа нь хотынхон зах зээлд илүү ойр байдагтай холбоотой байж болох юм. Тодруулбал, тамхи татаж үзсэн эмэгтэйчүүдийн хувь хотод 30 байхад хөдөөд 18, судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд архи, согтууруулах ундаа уусан эмэгтэйчүүдийн хувь хотод 27, хөдөөд 15 байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагын хувьд хөдөөгийн эмэгтэйчүүд хотын эмэгтэйчүүдээс илүүтэйгээр нөхөр нь эхнэрээ тодорхой тохиолдлуудад цохиж зодож болно гэдэгтэй санал нийлсэн (17 ба 6 хувь) байна.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд эрэгтэйчүүдийнхтэй ижил дүр зураг ажиглагдлаа.

# НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС БҮСЭР (15-54 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)




Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүртээмж Улаанбаатар хотод хамгийн сайн (34 хувь), Зүүн болон Хангайн бүсэд хамгийн муу (13-14 хувь) байна.

Архи, согтууруулах ундааны хэрэглээ Улаанбаатар хотын эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (56 хувь) байгаа бол тамхины хэрэглээ Төвийн болон Зүүн бүсийн эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (58-60 хувь) байна.

Баруун бүсийн 5 эрэгтэй тутмын 1 нь, Улаанбаатар хотын 20 эрэгтэй тутмын 1 нь нөхөр нь эхнэрээ тодорхой тохиолдлуудад цохиж зодж болно гэж үзсэн байна.

ХДХВ, ДОХ-ын талаар сонссон эрэгтэйчүүдийн хувь Төвийн бүс болон Улаанбаатар хотод хамгийн их (94 ба 79-83 хувь), түүнчлэн ХДХВ-ийн халдвартын талаарх шогц мэдлэгтэй эрэгтэйчүүдийн хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу бусдаас даруй 2 дахин их байна. Харин ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээ хаана өгөхийг мэддэг эрэгтэйчүүдийн хувь Баруун болон Хангайн бүсэд хамгийн бага (45-47 ба 54-76 хувь) байгаа бөгөөд энэ хэрээрээ уг шинжилгээг өгч, хариугаа авсан эрэгтэйчүүдийн хувь эдгээр бүсүүдэд хамгийн бага (6-7 ба 13-16 хувь) байна.

## 12 НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС БҮСЭЭР (15-49 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)







Эмэгтэйчүүдийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагыг бүсээр авч зэхэдээртэйчүүдийнхтэй ижил дүр зураг ажиглагдлаа.

Эмэгтэйчүүдийн тамхи, архи, согтууроо улаанбаатар хотод бусдаасаа өндөр (7-10 хувь, 24-28 хувь) байна.

Эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагыг бүсээр авч зэхэдээртэйчүүдийнхтэй ижил дүр зурагтай байна.

# НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС

## ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-54 НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮД)



Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүртээмж өрхийн аж байдлаас ихээхэн хамааралтай байна. Тодруулбал, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эрэгтэйчүүдийг доогуур түвшний аж байдалтай өрхийн эрэгтэйчүүдтэй харьцуулахад хэрэглээ нь 4 даруй дахин их байгаа юм.



Өрхийн аж байдал дээгүүр байх тусам эрэгтэйчүүдийн тамхины хэрэглээ бага (49 ба 54-58 хувь), харин архи, согтууруулах ундааны хэрэглээ их (58 ба 40-54 хувь) байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагын хувьд өрхийн аж байдал дээгүүр байх тусам эрэгтэйчүүд нөхөр нь эхнэрээ тодорхой тохиолдлуудад шохиж зодож болно гэж үзэх нь эрс багасч байна.

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, дадлын үзүүлэлтүүд эрэгтэйчүүдийн амьдарч буй өрхийн аж байдлаар илэрхий ялгаатай байхад хандлагын үзүүлэлтийн хувьд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна.

## 12 НӨХӨН ҮРЖИХҮЙН НАС

ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР (15-49 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД)



Эмэгтэйчүүдийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага, ХДХВ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг бүсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийнхтэй адил дүр зурагтай байна.

Харин дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ бусдаасаа нэлээд их байна. Тухайлбал, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийг доогуур түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад тамхи татаж үзсэн хувь нь 2.4, сүүлийн 1 сарын хугацаанд тамхи татсан хувь нь 3.3, архи, согтууруулах ундаа уусан хувь нь 3.7 дахин өндөр байгаа юм.

# **ХАВСРАЛТ**

**Судалгааны  
үзүүлэлтийн  
тодорхойлолт**

# ХАВСРАЛТ

## СУДАЛГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ҮЗҮҮЛЭЛТ <sup>[M]</sup>	БҮЛЭГ <sup>1</sup>	ХҮРТВЭР	ХУВААРЬ	MX3 <sup>2</sup>
<b>ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ</b>				
1.1 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	CM	5 нас хүрэхээсээ өмнө эндэх магадлал		MX3 4.1
1.2 Нялхсын эндэгдэл	CM	1 нас хүрэхээсээ өмнө эндэх магадлал		MX3 4.2
<b>ХҮҮХДИЙН ХООЛ ТЭЖЭЭЛ</b>				
2.1a 2.1b Тураалтай хүүхэд	AN	Биеийн жин, насны харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт биеийн жин, насны харьцааны голчоос хэлбэлзэж, Z оноо нь (a) -2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) -3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) байгаа 5 хүртэлх насны хүүхдийн тоо	5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо	MX3 1.8
2.2a 2.2b Θсөлт хоцролттой хүүхэд	AN	Биеийн өндөр, насны харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт биеийн өндөр, насны харьцааны голчоос хэлбэлзэж, Z оноо нь (a) -2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) -3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) байгаа 5 хүртэлх насны хүүхдийн тоо	5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо	
2.3a 2.3b Туранхай хүүхэд	AN	Биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-ын боловсруулсан стандарт биеийн жин, өндрийн харьцааны голчоос хэлбэлзэж, Z оноо нь (a) -2 стандарт хазайлтаас доогуур (дунд болон хүнд зэргийн) (b) -3 стандарт хазайлтаас доогуур (хүнд зэргийн) байгаа 5 хүртэлх насны хүүхдийн тоо	5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо	
2.4 Эхийн сүүгээр хооллоот	MN	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн бөгөөд хүүхдээ эхийн сүүгээр хооллож байсан эмэгтэйчүүдийн тоо	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн нийт эмэгтэйчүүдийн тоо	
2.5 Эрт амлүүлалт	MN	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн бөгөөд төрсний дараах 1 цагийн дотор хүүхэддээ ангир уургаа амлүулсан эмэгтэйчүүдийн тоо	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн нийт эмэгтэйчүүдийн тоо	
2.6 Эхийн сүүгээр дагнан хооллоот (0-5 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон (зөвхөн эхийн сүүгээр хооллосон бөгөөд шингэн сэлбэх давсны усмал, аминдэм, эрдэс бодис агуулсан ямар нэг бэлдмэл, бүтээгдэхүүн, эмнээс бусад ямар ч төрлийн шингэн зүйл уугаагүй эсвэл хоол идээгүй байх) 0-5 картай хүүхдийн тоо	0-5 картай нийт хүүхдийн тоо	
2.7 1 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллоот (12-15 cap)	BF	Эхийн сүүгээр хооллож байгаа 12-15 картай хүүхдийн тоо	12-15 картай нийт хүүхдийн тоо	
2.8 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллоот (20-23 cap)	BF	Эхийн сүүгээр хооллож байгаа 20-23 картай хүүхдийн тоо	20-23 картай нийт хүүхдийн тоо	

<sup>[M]</sup> Тус тэмдэглэгээ бүхий үзүүлэлтүүд нь холбогдох насны бүлгийн эрэгтэйчүүдийн хувьд мөн тооцогдсон болно. Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн насыг 15-54 гэж үзсэн тул нийт буюу 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд тооцогдсон үзүүлэлтүүд эрэгтэйчүүдийн хувьд 15-54 насны хувьд тооцогдсон.

<sup>1</sup> Зарим үзүүлэлтийг тооцоход хэд хэдэн бүлгийн мэдээлэл ашиглагдсан ба энэ тохиолдолд ихэнх мэдээллийг агуулж байгаа бүлгийн дугаарыг үзүүлсэн.

<sup>2</sup> Мянганы Хөгжлийн Зорилтын үзүүлэлтүүд, 2010 оны 2-р сарын байдлаар

	ҮЗҮҮЛЭЛТ <sup>[M]</sup>	БҮЛЭГ <sup>1</sup>	ХҮРТВЭР	ХУВААРЬ	МХЭ <sup>2</sup>
2.9	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн зүйл ууж байгаа хүүхэд (0-5 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн зүйл (эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, малын сүү, лаазалсан, савласан эсвэл хуурай сүү болон тарагнаас бусад) уусан 0-5 сартай хүүхдийн тоо	0-5 сартай нийт хүүхдийн тоо	
2.10	Эхийн сүүгээр хооллож байгаа голч нас (0-35 cap)	BF	0-35 сартай нийт хүүхдийн 50 хувь нь судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллоогүй байх нас, сараар		
2.11	Үгжаар шингэн зүйл уусан хүүхэд (0-23 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт үгжаар ямар нэг шингэн зүйл уусан 0-23 сартай хүүхдийн тоо	0-23 сартай нийт хүүхдийн тоо	
2.12	Нэмэгдэл хоолонд орсон хүүхэд (6-8 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт нэмэгдэл хоол (зутан, бантан, томчуудын хоол гэх мэт) идсэн 6-8 сартай хүүхдийн тоо	6-8 сартай нийт хүүхдийн тоо	
2.13	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа хүүхэд (6-23 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт нэмэгдэл хоолыг зохих давтамжаар (эхийн сүүгээр хооллож байгаа 6-8 сартай хүүхдийн хувьд нэмэгдэл хоолыг өдөрт хамгийн багадаа 2 удаа, 9-23 сартай хүүхдийн хувьд өдөрт хамгийн багадаа 3 удаа, эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдийн хувьд сүүн шингэн зүйл (эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, малын сүү, лаазалсан, савласан эсвэл хуурай сүү болон тараг) болон нэмэгдэл хоолыг өдөрт хамгийн багадаа 4 удаа) идсэн 6-23 сартай хүүхдийн тоо	6-23 сартай нийт хүүхдийн тоо	
2.14	Насандaa тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд (0-23 cap)	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон 0-5 сартай, эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн 6-23 сартай хүүхдийн тоо	0-23 сартай нийт хүүхдийн тоо	
2.15	Эхийн сүүгээр хооллохгүй байгаа бөгөөд сүүн шингэн зүйлийг зохих давтамжаар ууж байгаа хүүхэд	BF	Судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллоогүй бөгөөд сүүн шингэн зүйлийг (эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, малын сүү, лаазалсан, савласан эсвэл хуурай сүү болон тараг) наад зах нь 2 удаа уусан 6-23 сартай хүүхдийн тоо	Судалгаанаас өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллоогүй 6-23 сартай нийт хүүхдийн тоо	
2.16	Өрхийн иоджуулсан давсны хэрэглээ	SI	Хоолондоо хэрэглэдэг давсиг нь шинжлэхэд 15 ба түүнээс дээш PPM бүхий иодын агууламжтай байсан өрхийн тоо	Хоолондоо хэрэглэдэг давсиг нь шинжилсэн болон давсгүй байсан нийт өрхийн тоо	
2.17	А аминдэмийн хангамж	IM	Судалгаанаас өмнөх 6 сарын хугацаанд өндөр тунт А аминдэмийн тосон бэлдмэлийг наад зах нь 1 удаа уусан 6-59 сартай хүүхдийн тоо	6-59 сартай нийт хүүхдийн тоо	

# ХАВСРАЛТ

## СУДАЛГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ҮЗҮҮЛЭЛТ <sup>[M]</sup>		БҮЛЭГ <sup>1</sup>	ХҮРТВЭР	ХУВААРЬ	MX3 <sup>2</sup>
2.18	Бага жинтэй төрсөн хүүхэд	MN	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд амьд төрсөн (төрүүлсэн эхийн хувьд сүүлийн хүүхэд) бөгөөд төрөх үеийн жин нь 2,500 граммаас бага байсан хүүхдийн тоо	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд амьд төрсөн (төрүүлсэн эхийн хувьд сүүлийн хүүхэд) нийт хүүхдийн тоо	
2.19	Төрөх үед нь жиналсан хүүхэд	MN	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд амьд төрсөн (төрүүлсэн эхийн хувьд сүүлийн хүүхэд) бөгөөд төрөх үед нь биений жинг нь хэмжсэн хүүхдийн тоо	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд амьд төрсөн (төрүүлсэн эхийн хувьд сүүлийн хүүхэд) нийт хүүхдийн тоо	
<b>ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД</b>					
3.1	Сүрьеэгийн эсрэг вакцинд хамрагдарт	IM	Сүрьеэгийн эсрэг вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.1a	Халдварт саагийн эсрэг вакцины төрөх үеийн тунд хамрагдарт	IM	Халдварт саагийн эсрэг вакцины төрөх үеийн тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.1b	Халдварт саагийн эсрэг вакцины 1-р тунд хамрагдарт	IM	Халдварт саагийн эсрэг вакцины 1-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.1c	Халдварт саагийн эсрэг вакцины 2-р тунд хамрагдарт	IM	Халдварт саагийн эсрэг вакцины 2-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.2	Халдварт саагийн эсрэг вакцины 3-р тунд хамрагдарт	IM	Халдварт саагийн эсрэг вакцины 3-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.2a	Гуравт/ тавт вакцины 1-р тунд хамрагдарт	IM	Гуравт/ тавт эсрэг вакцины 1-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.2b	Гуравт/ тавт вакцины 2-р тунд хамрагдарт	IM	Гуравт/ тавт эсрэг вакцины 2-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.3	Гуравт/ тавт вакцины 3-р тунд хамрагдарт	IM	Гуравт/ тавт эсрэг вакцины 3-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
3.4	Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 1-р тунд хамрагдарт	IM	Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцины 1-р тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	MX3 4.3
3.5	Б гепатитын эсрэг вакцинд хамрагдарт	IM	Б гепатитын эсрэг вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн тоо	12-23 сартай нийт хүүхдийн тоо	
